



ФАТФ-ын тайлан

**АЛТНЫ САЛБАР ДАХЬ
МӨНГӨ УГААХ/
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ
ЭРСДЭЛ, ЭМЗЭГ
БАЙДАЛ**

2015 оны 7 дугаар сар



Ишлэл татах:

ФАТФ ба АНДМУТБ (2015), АЛТНЫ САЛБАРЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ ,

FATF, Paris and APG, Sydney

www.fatf-gafi.org/topics/methodsandtrends/documents/ml-tf-risks-and-vulnerabilities-gold.html

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

ФАТФ - АНДМУТБ алтны салбарын судалгааг хамтарч хийсэн гол шалтгаан нь хянан шалгах, хууль сахиулах эрх бүхий байгууллагууд албан ёсны санхүүгийн салбар болон бэлэн мөнгөний зах зээлийг илүү чангатгаснаар мөнгө угаах (МУ) болон терроризмыг санхүүжүүлэх (ТС) үйл ажиллагаа эдгээр салбараас шахагдаж алтны зах зээл рүү шилжсэнтэй холбоотой болно.

2-р бүлэгт гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэг хөрөнгөө алтыг ашиглаж, хөдөлгөхөд хүргэдэг алтны онцлог шинж чанаруудыг тодорхойлсон болно.

3-р бүлэгт алтны зах зээл дээр гарч буй суурь гэмт хэрэг (хулгай, хилээр хууль бусаар барааг нэвтрүүлэх, залилан, хууль бус үйл ажиллагаа, татвараас зайлсхийх гэмт хэрэг)-ийг илрүүлэх зорилгоор алтны олборлолт, зах зээл, арилжааны мөн чанар, гарал үүсэл, цар хүрээг харуулсан болно. Эдгээр үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа талаар илүү нарийн ойлголттой болох нь МУТС үйл ажиллагааг таньж мэдэхэд шаардлагатай.

4-р бүлэгт санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид (СББМҮҮ), санхүүгийн байгууллагууд болон бусад алтны салбарт МУТС-тэй холбоотой гарч буй сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх, мэдээлэхэд туслах “сэжиглэх үндэслэл” шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн санг бий болгосон.

Энэхүү тайлангийн гол үр дүн нь эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй болгох, мөн мөрдөн шалгах шаардлагатай байгаа салбарт цаашид хийх ажлыг дэмжихэд чиглэгдсэн болно.

Судалгааны гол үр дүн:

- Алт нь мөнгө угаах гэмт хэрэгт ашиглагддаг түгээмэл бүтээгдэхүүн юм. Учир нь алт нь гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэгт хууль бусаар олсон хөрөнгөө тогтвортой бөгөөд нууц, хөрвүүлэх боломжтой, амархан сольж болохуйц хөрөнгө болгож, ашгаараа дахин хөрөнгө оруулалт хийх тогтолцоог бүрдүүлж өгдөг.
- Алтны зах зээл нь өндөр ашигтай тул гэмт хэргийн үйл ажиллагааны бай болдог. Алтны зах зээлийн тасралтгүй үргэлжлэх янз бүрийн үе шат бүрт үйлдэгдэж болох гэмт хэргийн төрлийг ойлгох нь энэ салбарт гарч буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.
- Алтны зах зээлд гарч буй гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход зохицуулалт хийх ач холбогдол болон алтны зах зээл ба терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн уялдаа холбоог тогтоох зорилгоор цаашид нарийн судалгаа хийх шаардлагатай байна. Энэхүү санхүүгийн урсгал ба алтны зах зээлийн харилцан хамаарлын талаарх судалгаа нь гэмт хэрэгтнүүд хэрхэн алт, алтан эдлэлийг мөнгө угаах зорилгоор ашигладаг талаар илүү сайн ойлголттой болоход шаардлагатай юм.

1. ОРШИЛ

Эртний цаг үеэс эхлэн янз бүрийн соёл иргэншилд алтыг төлбөрийн хэрэгсэл болгон ашиглаж ирсэн. Түүхээс харахад засгийн газрууд алт гэх мэт бодит түүхий эдээс зоос гаргаж, эсвэл тодорхой тооны бараа бүтээгдэхүүнийг эргүүлэн авах боломжтой цаасан мөнгийг хэвлэж байв (Алтан стандарт). Орчин үеийн ихэнх цаасан мөнгөн тэмдэгтийг “фиат валют” гэж нэрлэдэг. Тэдгээр нь бодит үнэ цэнэгүй бөгөөд зөвхөн төлбөрийн хэрэгсэл болон ашиглагддаг. Орчин үед фиат мөнгөний хэрэглээ өндөр байгаа ч үнэт металл нь бодит үнэ цэнэ, хялбар хөврүүлэх боломжтой шинж чанараасаа шалтгаалан төлбөрийн хэрэгслийн нэгэн хувилбар хэвээр байна.

Сүүлийн үед дэлхийн эдийн засагт гарсан өөрчлөлтүүдээс шалтгаалан түүхий эдийн эрэлт, түүний тогтвортой хөрөнгө оруулалт нэмэгдсэн. Алтны үнэ цэнэ дэлхийн санхүүгийн зах зээлийн хэлбэлзэлтэй байдлаас үл хамааран тогтвортой хэвээр байгаа бөгөөд алт нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн валют юм. Олон улсын мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээ нь гэмт хэрэгтнүүдийг хуулийн хяналт багатай салбар руу шилжихэд нөлөөлж байгаа тул алт нь тэдний сонирхлыг маш ихээр татаж байгаа билээ. Цаашилбал, алт бол Хятад, Энэтхэг зэрэг олон орны соёлын өв, шашин, нийгмийн салшгүй хэсэг юм.

Очир эрдэнийн салбартай адилаар алтны салбарыг (үнэт металлын худалдаа эрхлэгчдээр дамжуулан) ФАТФ-ын стандартын 23-р зөвлөмж - Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид (СББМҮҮ)-д тусгасан болно. Гэсэн хэдий ч очир эрдэнийн салбартай адил алтны салбар нь бусад СББМҮҮ-ээс ялгаатай.

Энэхүү судалгаа нь алтны зах зээлийн бүх шинж чанаруудыг тодорхойлоход зориулагдаагүй - алтны салбар нь нарийн төвөгтэй бөгөөд энэ сэдвийг дэлгэрэнгүй хамарсан олон тооны судалгаанууд байдаг. Алтны зах зээлийн эмзэг байдлыг үр дүнтэй ойлгохын тулд энэхүү судалгааг бусад тайлангуудтай хамт унших хэрэгтэй. Жишээлбэл:

- Алтны бүх салбарын засаглал, дүрмийг сайжруулах чиглэлээр шаргуу ажиллаж буй Дэлхийн алтны зөвлөлийн захиалгаар PWC-ийн бичсэн "Алтны эдийн засагт үзүүлэх шууд нөлөөлөл". Энэхүү судалгааны ажил нь алтны үнэ цэнэ бүхий гинжин хэлхээг бүхэлд нь өвөрмөц байдлаар харах боломжийг олгодог.
- Их Британийн Үнэт эдлэлчдийн холбоо, Алтан эдлэлийн үндэсний холбооны хамтран гаргасан "Алтны судалгаа".

Алтны салбарын талаарх одоо байгаа судалгааг тоймлон авч үзэхийн зэрэгцээ энэхүү тайлан нь олон улсын төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай дараах чиглэлээр зөвлөлдсөний үр дүн юм.

- *Алтны зах зээлд оролцдог төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын санал асуулгын хариулт.*

Тусдаа асуулгыг хамаарал бүхий байгууллагуудаар бөглүүлэх зорилгоор ФАТФ, АНДМУТБ болон бусад ФАТФ-ын төрлийн бүсийн

байгууллага (ФТББ) -уудаар дамжуулан Засгийн газар, хувийн хэвшилд тараав. Эдгээр хариулт дээр дүн шинжилгээ хийх нь олон улс орнуудын дунд түгээмэл алтны зах зээлийн МУТС-тэй холбоотой эмзэг байдлыг ойлгоход тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, баталгаажуулахад тусалсан болно.

□ *Хууль сахиулах байгууллагаас гаргасан кейс (хэргийн) судалгаа.*

Энэхүү тайланд үйл ажиллагааны орчныг дүрслэх, МУТС үйл ажиллагааг тодорхойлохын тулд "сэжиглэх үндэслэл" -ийг боловсруулахад туслах цөөн тооны хэргийн/кейс судалгааг ашигласан болно.

2. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ХЭРЭГСЭЛ АЛТ - НОЦТОЙ ЭМЗЭГ БАЙДАЛ.

Алт ба алтны зах зээлийн хоёр шинж чанар нь зохион байгуулалттай гэмт бүлгийн сонирхлыг ихээр татдаг. Эхний шинж чанар нь бэлэн мөнгөнөөс их хамаардаг зах зээлийн мөн чанар ба хэмжээ нь. Хоёрдахь шинж чанар нь алтны нэрээ нууцлах боломж олгодог байдал бөгөөд энэ нь хөрөнгийн гарал үүслийг мөрдөхөд маш хэцүү болгодог байна. Эдгээр хүчин зүйлүүд нь гэмт хэргээс олсон орлогоо нуух, тээвэрлэх, хөрөнгө оруулах хүсэлтэй зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн алтанд маш их татагдах шалтгаан болдог.

Алтны зах зээл нь бэлэн мөнгө их ашигладаг

Олон улс орны алтны зах зээлийн хяналт, зохицуулалт сул байна. Иймд зохион байгуулалттай гэмт бүлэг хууль бусаар олсон орлогоо зохицуулалттай санхүүгийн салбарт байршуулах, нэгтгэх зорилгоор алтны арилжаа эрхлэхэд таатай нөхцөл бүрддэг болно. Энэ салбарт хяналт сул, тусгай зөвшөөрөл төдийлөн шаардагддаггүй тул алтыг бэлэн мөнгөөр солидог бизнес эрхлэгчид гэмт бүлгүүдийг олон төрлийн гарал үүсэл нь тодорхойгүй алтаар тасралтгүй хангах эрсдэлтэй юм. Түүнчлэн, энэхүү алтны нийлүүлэлтийг зах зээлээс доогуур үнээр, алтны гарал үүслээ баталгаажуулах шаардлагагүй олон нийтээс шууд худалдаж авдаг байна.

Эдгээр бэлэн мөнгөөр үйл ажиллагаа эрхэлдэг бизнесээр дамжуулан хийсэн их хэмжээний, бага дүнтэй гүйлгээг хуурамчаар үйлдэх, гэмт хэргийн орлоготой нэгтгэх боломжтой бол худалдаж авсан алтыг хууль бус бараа, үйлчилгээний төлбөр хийхэд ашиглаж болно. Ихэнх дахин боловсруулсан түүхий эдийг бэлэн мөнгөөр худалдаж авдаг тул олон тооны гүйлгээг нэрээ нууцлан хийсээр байна.

Мөнгө угаах шаардлагатай хүмүүс, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдсон хүмүүс алтны арилжаанаас ашиг олох магадлал өндөр бөгөөд ихэнх улс орны зохицуулалт, хяналт бага байдаг тул энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхэд амархан байдаг. Өмнө нь гэмт хэрэг үйлдэж байгаагүй хүмүүс үйл ажиллагааны үндсэн зорилго нь мөнгө угаах гэж сэжиглэж байсан ч эрсдэл хүлээхэд бэлэн байна.

Хууль ёсны ба хууль бус дахин боловсруулсан алтны худалдаанд аль алинд нь бага хөрөнгө оруулалт шаардагддаг тул энэхүү үйл ажиллагаа нь түгээмэл байдаг бөгөөд үйл ажиллагааг нээх, хаахад бага зэргийн бэрхшээл тулгардаг. Энэ нь зохицуулагч байгууллагад эдгээр үйл ажиллагаанд хяналт тавихад бэрхшээл учруулдаг.

1-р кейс судалгаагаар хэрхэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис борлуулж олсон бэлэн мөнгийг алтаар сольж, гуравдагч этгээд болох мөнгө угаах гэмт бүлгээр дамжуулан хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлж байгааг харуулав.

Кейс судалгаа 1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын борлуулалтаас олсон орлогыг угаахад гуравдагч этгээд хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлдэг гэмт бүлгийг ашигласан хэрэг

2014 оны эхээр Францын цагдаа нар Парис мужид каннабис зарж олсон орлогыг угаах үйлчилгээ үзүүлдэг олон улсын мөнгө угаадаг сүлжээг илрүүлжээ. Энэхүү хэргийн судалгаагаар Францын хууль сахиулах байгууллагын мөрдөн байцаах ажиллагааны үр дүнг нэгтгэн харуулав. Мороккогийн дилерүүд каннабисийг Францруу хууль бусаар хил нэвтрүүлж, гудамжинд зардаг байв.

Гудамжны борлуулалтаас олсон орлогыг цуглуулах ажлыг Энэтхэг улсын иргэн (2014 оны 3-р сард баривчилсан) зохион байгуулжээ. Энэхүү мөнгө цуглуулах үйл ажиллагааг (гэмт хэрэгтнүүд “амана” гэж нэрлэдэг) гэмт хэрэгт оролцоогүй боловч гэмт хэргийн орлоготой харьцаж буй гэдгээ мэддэг "салафууд" (мөнгөний луус) гэгч хүмүүс хийсэн байна. Энэ нь зохион байгуулалттай гэмт бүлгийн суурь гэмт хэрэг болон салафуудыг салгах санаатай шийдвэр байжээ. Үйл ажиллагааны үүргийг хуваах нь тухайн орлого, мөнгө нь тодорхой гэмт хэргийн орлого гэдгийг батлахад хэцүү болгодог бөгөөд олон оронд энэхүү баталгаа нь мөнгө угаах гэмт хэргийг нотлоход шаардлагатай юм.

Энэ тохиолдолд судалгаа хийхэд салафууд Мороккогийн хар тамхины наймаачдын захиалгыг авч, мөнгөө Энэтхэгийн иргэнд шилжүүлжээ. Мөрдөн байцаалтаар салафууд зургаан сарын хугацаанд 10 сая гаруй евро цуглуулсан байсныг олж тогтоожээ. Энэтхэг үндэстэн Францад олны анхааралд өртөхөөргүй байр суурьтай байсан (тэрбээр эхнэрийнхээ халамжийн тэтгэмжээс өөр албан ёсны орлогогүй, Парисын захын хороололд нийгмийн орон сууцанд амьдардаг байсан) боловч Энэтхэгт олон тооны үнэт хөрөнгө эзэмшиж байжээ.

Бэлэн мөнгөө хүлээн авсны дараа Энэтхэг үндэстэн бэлнээр нь мөнгөө Бельги улс-руу машинаар тээвэрлэж, тус улсад алт, үнэт эдлэл худалдаж авахад ашиглаж байсан. Бэлэн мөнгөний дийлэнх хэсгийг нэгэн алтны арилжаа эрхлэгчтэй холбоотой компаниудын өөр өөр дансанд байршуулж, бөөний худалдааны төвөөс алт худалдаж авахад ашигладаг байв. Хууль сахиулах байгууллагынхан алтан зоос, гулдмай, алтны гэрчилгээтэй холбоотой гүйлгээний талаар лавлах бүрт Энэтхэг этгээдийн үйлдсэн хуурамч нэхэмжлэхийг (түүний байгуулсан компаниудын нэр дээр) ашиглан тайлбарлаж, баталгаажуулдаг байв.

Мөрдөн байцаалтаар алтыг Энэтхэг рүү зөөхөд ашигладаг хоёр гол арга замыг тогтоожээ.

Эхний маршрут: Үнэт эдлэл ба алтыг Дубай руу хуурамч нэхэмжлэх, хуурамч компаниудыг ашиглан илгээсэн байна. Гүйлгээ нь саадгүй хийгдсэн тохиолдолд эдгээр хуурамч нэхэмжлэхийг устгаж, хэрэв үгүй бол гүйлгээг тайлбарлахад ашигладаг байжээ. Мөрдөн байцаалтаар алтны наймаачин 11 сарын хугацаанд 190 кг алт зарж, ойролцоогоор 6 сая еврогийн үнэ бүхий албан ёсны бүртгэлийг хөтөлсөн болохыг тогтоожээ. Гэсэн хэдий ч мөрдөн байцаалтаар тогтоосны дагуу зохион байгуулалттай гэмт бүлгийн алтны хэрэгцээ долоо хоногт 20 килограмм алтны хэмжээтэй ойролцоо байв. Үлдсэн алтны талаархи нарийн мэдээллийг тогтоогоогүй байна.

Энэтхэгийн иргэн өөрийн төрөл төрөгсдийг алтыг Энэтхэг, АНЭУ руу тээвэрлэхэд ашигласан бөгөөд нэг хамаатан нь 2008 оноос 2014 оны хооронд Энэтхэг ба Арабын нэгдсэн

Эмират улсын хооронд нийт 200-аас дээш удаа (сард хоёроос гурван удаа) зорчсон байна. Энэтхэг дахь зохион байгуулалттай гэмт бүлгийн тэргүүн тус улсад аялал жуулчлалын агентлаг эзэмшдэг байсан бөгөөд мөнгө тээвэрлэгчид нислэгийн тийз өгч, заримдаа алт худалдаж авахад хуурамч нэхэмжлэх өгдөг байв. Мэдээллийн дагуу алтыг Дубай руу хууль бусаар нэвтрүүлээгүй боловч хуурамч нэхэмжлэхийг халхавч болгон ашиглан албан ёсоор экспортолж, гаальд мэдүүлжээ.

Эхний тохиолдолд алтыг Дубайруу тээвэрлэж, нутгийн иргэд эсвэл Энэтхэгийн иргэдэд зарж борлуулдаг байв (хавалаг ашиглаж). Алт зарж олсон орлогыг Дубай дахь зохицуулалттай гадаад валютын үйл ажиллагаагаар дамжуулан Мороккогийн хар тамхины наймаачдад төлбөр болгон шилжүүлдэг байв. Үлдсэн алтыг Дубайд байрлах аялал жуулчлалын байгууллагын ажилтны туслалцаатайгаар мөнгө тээвэрлэгчдийг 220 еврогоор хөлсөлж Энэтхэгрүү хууль бусаар хил нэвтрүүлж байв. Мөрдөн байцаагчдийн тогтоосноор энэ үйл ажиллагаанд хосууд, хөгшчүүл, нэг удаа бүр бага насны хүүхэд оролцсон байжээ. Алтыг нуухад хялбар болгох үүднээс алт мөнгөн эдлэлийн дархан алтан цаас, 100 гр алтанд дусал, үнэт эдлэл боолгон хувиргаж, кофе, бүр бие дотор хүртэл нуудаг байжээ.

Хоёр дахь маршрут: Бельгис Энэтхэг рүү алтыг тээвэрлэх өөр нэг зам нь Бангкок, Сингапурын олон улсын нисэх буудлуудаар дамжуулан Мьянмарын мэргэжлийн хууль бус хилээр бараа, бүтээгдэхүүн тээвэрлэгчид хүргэх байв. Дараа нь алтыг Мьянмараар дамжуулж Энэтхэг рүү зарж борлуулдаг байжээ.

Францын гудамжнаас мөнгө цуглуулж эхэлснээс хойш ашигласан маршрутаас үл хамааран мөнгө угаагч нар Мороккогийн чимээгүй хамтрагчдаа мөнгөө буцааж төлөхөд ердөө таван өдөр зарцуулдаг байжээ.

Энэтхэг зохион байгуулалттай гэмт бүлэг алтыг хөрвүүлж, дахин борлуулах замаар ашиг олдог байв. Алтыг хууль бусаар хилээр оруулж, татвараас зайлсхийх замаар Энэтхэгийн зохион байгуулалттай гэмт бүлэг алтаа бусад алт арилжаалагчдаас хямд борлуулж, ашиг олж чадсан юм. Тус алтыг Бельги улсаас нэг граммыг нь 31 еврогоор худалдаж авсан бөгөөд Дубай эсвэл Энэтхэгт нэг грамм алтыг 36.32 еврогоор зарсан байна. Бельгийн алтны наймаачин нэг кг тутамд 325 еврогийн шимтгэл авсан бөгөөд энэ нь зохион байгуулалттай гэмт бүлгийн хувьд нэг кг тутамд 5 000 еврогийн ашиг болж байгаа юм.

Энэтхэгийн зохион байгуулалттай гэмт бүлгийн ашигладаг энэхүү систем нь маш ашигтай байсан тул Энэтхэг үндэсэтэн ердийн угаасан мөнгөнөөс олдог 2.25% -ийн ногдол ашгаасаа татгалзжээ. Түүний цорын ганц хүсэл бол алтыг дахин дахин худалдаж авахын тулд аль болох их аманасувгыг ашиглан мөнгө хураах явдал байв. Ийнхүү тэрбээр Мороккогийн түншдээ мөнгөө үнэгүй угаах онцгой боломжийг санал болгов.

Эх сурвалж: Францын үндэсний цагдаагийн газар (DCPJ)

Доорх 2-р кейсийн судалгаанд алтыг бэлэн мөнгөөр худалдаж авах нь гэмт хэргийн бүлгүүдэд хөрөнгөө зохицуулалттай санхүүгийн салбарт байршуулах, халхлах, нэгтгэх боломжийг хэрхэн олгодог болохыг харуулав.

Кейс судалгаа 2. Хар тамхины наймаанаас олсон орлогыг хууль ёсны болгох зорилгоор алт худалдаалах

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын мөрдөн байцаах алба хар тамхины наймаа эрхэлдэг бүлэг гэмт хэргээс олсон орлогоо алт худалдан авахад ашиглаж байсан тогтолцоог илрүүлжээ.

Гэмт хэргийн бүлэг АНУ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын борлуулалтаас олсон хууль бус орлогыг ашиглан янз бүрийн үнэт металлын жижиглэн худалдаа эрхлэгчдээс алт худалдан авч байжээ. Улмаар алтыг үнэт металлын зуучлагчид зарж, дараа нь зуучлагч бусад арилжаа эрхлэгчдэд зардаг байжээ.

Борлуулалтаас олсон орлогоо АНУ-аас гадуур хар тамхины наймаатай холбоотой гуравдагч этгээдэд шилжүүлэн мөнгө угаах гэмт хэрэг үйлддэг байжээ.

Эх сурвалж: АНУ-ын ДАБ МБА

АЛТЫГ НУУЦААР АРИЛЖААЛАХ БОЛОМЖТОЙ БӨГӨӨД ГҮЙЛГЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ ОЛОХ, БАТАЛГААЖУУЛАХАД ХҮНДРЭЛТЭЙ.

Бельгид хийсэн дараах хэргийн судалгаанаас харахад алттай холбоотой олон гүйлгээ нь нэр нь тодорхойгүй, алт худалдагч, худалдан авагчийг тодорхойлоогүйгээр хийсэн тохиолдол гардаг. Энэ нь алтны гарал үүсэл эсвэл түүнийг зарж борлуулсан этгээдийг тодорхойлоход хууль сахиулах байгууллагуудад хүндрэл учруулдаг. Алтыг зөв тодорхойлоход бэрхшээлтэй тул алтны гарал үүслийн талаарх худал мэдүүлгийг үндэслэлгүй болохыг нотлоход хэцүү байх магадлалтай.

Кейс судалгаа 3. Алтыг нэрээ нуун дарагдуулж худалдаж авах, зарах

Үнэт металлын худалдаа эрхэлдэг хүн (бөөний худалдаа эрхлэгч А) Бельгид олон төрлийн банкинд данс эзэмшдэг байжээ. Эдгээр дансанд дүн шинжилгээ хийсний үр дүнд бөөний худалдаа эрхлэгч А үнэт металлын нийлүүлэгчдэд төлбөрөө бэлнээр төлдөг болохыг олж тогтоосон. Тэрбээр нэг жилийн хугацаанд нийт 800 сая еврогоос давсан дүнг бэлнээр авсан байжээ. Энэ данс нь ихэвчлэн Бельгийн банкнаас алтан гулдмай худалдан авах төлбөр хүлээн авдаг байсан.

Компани/арилжаа эрхлэгч Б нь ашигласан алтаа бөөний худалдаа эрхлэгч А-д нийлүүлж, бэлнээр төлбөрөө хүлээж авдаг байв. Компани/арилжаа эрхлэгч Б мөн алт нийлүүлэгчдээ төлбөрөө бэлнээр төлдөг байжээ. Санхүүгийн бүртгэлдээ тэрбээр нийлүүлэгч компаниудыг хэн болохыг нь тодорхойлолгүйгээр хувь хүн хэлбэрээр бүртгэсэн байв. Компани/арилжаа эрхлэгч Б нь алт эзэмшигчийн хууль бус үйл ажиллагааг далдлах, өөрөөр хэлбэл алтыг бэлэн мөнгөөр солих замаар гэмт хэргээс олсон орлогыг нь угаасан гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа юм.

Цагдаа нар бөөний худалдаа эрхлэгч А-г мөнгө угаах гэмт хэрэгт холбоотой гэдгийг мэддэг байв. Түүний үйлчлүүлэгчид нь ихэвчлэн дансанд нь "хувь хүмүүс" гэж бүртгэгдсэн Антверпен хотын алт зардаг дэлгүүрүүд, хувь хүмүүс ба зуучлагчид байжээ. Бөөний худалдаа эрхлэгч А нь үйлчлүүлэгчдээс ямар нэгэн бичиг баримт, үнэмлэхийг нь асуудаггүй

бөгөөд алтны гарал үүслийн талаар лавладаггүй байв. Мөрдөн байцаалтаар түүний худалдаж авсан алтны дийлэнх нь "хар зах" (үнэт эдлэлийн хулгай), мөн биеэ үнэлэх, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн орлогоос гаралтай гэж тогтоогдсон. Бөөний худалдаа эрхлэгч А нь алтны төлбөрийг бэлэн мөнгөөр хийж, их хэмжээний алтыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТС) -эд мэдээлэх шаардлагатай босго дүн буюу 15,000 еврогоос хэтрэхгүй байхаар хувааж худалдан авалт хийдэг байсан юм.

Цагдаагийн газар компани/арилжаа эрхлэгч Б-ээс гадна бөөний худалдаа эрхлэгч А-гийн бусад нийлүүлэгчдийг мөн мэддэг байв. Энэ нь бөөний худалдаа эрхлэгч А нь гэмт хэргээс олсон орлогыг угаахад ашиглагдаж байна гэсэн хардлагад хүргэсэн. Нэрийг нь нууцалж, бэлэн мөнгөөр төлбөр хийх нь гэмт хэрэгтнүүдийг татдаг байна

Эх сурвалж: Бельгийн Санхүүгийн мэдээллийн алба

АЛТ НЬ ДЭЛХИЙН ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛИЙН НЭГ ТӨРӨЛ БӨГӨӨД ГЭМТ ХЭРГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ СОЛИЛЦОХ ХЭРЭГСЭЛ БОЛДОГ.

Алт нь өвөрмөц үнэ цэнэтэй бөгөөд дэлхий даяар бусад валют руу хөрвөх чадвартай тул алтыг бэлэн мөнгөний оронд өр төлбөрийг барагдуулах, гэмт хэргээс олсон орлогыг хуваарилахад ашиглаж болдог. Олон улсын хавала сүлжээнүүдийг ажиллуулдаг зарим үндэстнүүд алтыг хоорондын төлбөр, тооцоог барагдуулахад ашигладагийг нь тогтоогджээ. (хэдийгээр алтыг ийм үйл ажиллагаанд ашиглах нь хууль бус биш юм) 4-р кейсийн судалгаагаар урьд нь банкны менежер байсан, албан ёсны банкны салбарын талаар маш сайн мэдлэгтэй зохион байгуулалттай гэмт бүлгийн удирдагч алтыг мөнгө угаах, гэмт хэргийн хамсаатнууддаа үйлчилгээнийх нь төлбөрийг төлөх стратегийн арга гэж тодорхойлсон байгааг харуулна.

Үүнтэй адилаар 5-р кейсийн судалгааны үеэр авилга авсан албан тушаалтан авилга хээл хахуулийг эхнэртээ алт хэлбэрээр өгч, өөрийгөө авилгын хэргээс холдуулахыг хүсчээ.

Кейс судалгаа 4. Томоохон хар тамхины зохион байгуулалттай гэмт бүлэг ажилчдаа алтаар цалинжуулсан хэрэг

Мөрдөн байцаалтын үр дүнд урд нь банкны менежер байсан хувь хүн маш нарийн зохион байгуулалттай, нөөц, бололцоо ихтэй хар тамхины бүлгийн толгойлогч болох нь тогтоогджээ. Сэжигтэн олон сая долларын каннабис ба амфетамин үйлдвэрлэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, туслалцаа үзүүлэх ажилд оролцож байсан бөгөөд хэд хэдэн алдартай гэмт хэрэгтнүүдтэй холбоотой байсан гэсэн таамаг байна.

Энэхүү үйл ажиллагааны тэргүүн нь хар тамхины гэмт бүлгээс алт худалдан авах, худалдах, үхэр худалдаж авах, мөрийтэй тоглоомоор дамжуулан мөнгө угаасан хэрэгт сэжиглэгджээ. Эрх баригчид сэжигтнүүд алтыг алт олборлогчдоос хямд үнээр бэлэн мөнгө ашиглан худалдан авч, дараа нь алтыг хамааралгүй аж ахуй нэгжүүдэд зарж, хууль ёсны орлого гэж мэдэгдсэн гэж үзэж байна. Цагдаагийн ажилтнууд зохион байгуулалттай гэмт бүлгийн нуусан их хэмжээний алтан гулдмай, 161,000 австрали долларын бэлэн мөнгийг илрүүлжээ.

Тус хууль бус үйл ажиллагаанд оролцсон хүмүүс өндөр цалинтай байсан бөгөөд зарим нь хар тамхи, алт хэлбэрээр урамшуулал авдаг байв. Нэгэн ажилтанд энэхүү үйл ажиллагаанд

оролцсон нэг жилийн хугацаанд нь нийт 250,000 австрали доллартай тэнцэхүйц бэлэн мөнгө, хар тамхи, алтаар цалинг нь олгожээ. Зохион байгуулалттай гэмт бүлгийн толгойлогч нар ургац хураалт бүрээс 300,000 австрали доллараас дээш бэлэн мөнгө, түүнчлэн алтан гулдмайгаар цалинждаг байв.

Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн эсрэг эрүүгийн хуулийн хүрээнд арга хэмжээ авсан бөгөөд хөдөө, орон нутаг дахь эд хөрөнгө, үхэр, автомашин, 220,000 австрали доллар ба их хэмжээний алт зэрэг 4 сая гаруй австрали долларын эд хөрөнгийг нь царцаажээ. Хууль сахиулах гүйцэтгэх ажиллагаа явуулснаар олон тооны зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүдийг баривчилж, удаан хугацаагаар цагдан хорих ял оноожээ.

Эх сурвалж: Австралийн СМА

Кейс судалгаа 5. Авилгын гэмт хэрэг үйлдэхэд алт ашиглах - гэмт этгээдүүдийг холбох банкны гүйлгээ байхгүй хэрэг

Дарга А нь аж үйлдвэрийн төсөлд гэрээ байгуулах үүрэгтэй Энэтхэгийн төрийн байгууллагын тэргүүн бол иргэн Б нь төрийн байгууллагатай гэрээ байгуулахаар өргөдөл гаргасан компанийн захирал юм. Иргэн Б нь дарга А-ийн найз В-д хандан түүнд 2 сая энэтхэг рүпийн хахууль өгч, уг гэрээг байгуулах зорилготой байв.

Дарга А нь иргэн Б, В нарыг түүний эхнэртэй холбоо барьж, хахуулийн мөнгөө хэрхэн өгч болох талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг зааварчилжээ. Дарга А-ийн эхнэр бэлэн мөнгийг алт болгон хувиргаж өгөхийг хүсэв. Иргэн Б-ийн түүнд өгсөн алтыг тэр банкны сейфэнд хадгалуулсан айна.

Уг авилгын талаар нууц мэдүүлэг өгсний дагуу Энэтхэгийн Мөрдөн байцаах төв товчоо дарга А-д холбогдох хэргийг бүртгэж, түүний байр, шүүгээнд нэгжлэг хийж, алтыг нь хурааж авав.

Мөрдөн байцаах төв товчоо нь гэмт этгээдүүдийг Энэтхэгийн Мөнгө угаах тухай тогтоолын дагуу суурь гэмт хэрэг болох Авилгын урьдчилан сэргийлэх тухай хуулиар гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгаж, 10 кг алтыг мөнгө угаах мөрдөн байцаалтын хүрээнд царцаасан.

Эх сурвалж: Энэтхэг улсын Хууль сахиулах ажиллагааны газар

АЛТНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БАТАЛГААТАЙ АШИГ ӨГДӨГ.

Мөнгөний зах зээлд алтыг актив хөрөнгө болгон ашиглах нь эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтворжуулдаг байна. Үүний гол шалтгаан нь жирийн хөрөнгө оруулагчийн хувьд алтны арилжаа илүү ойлгомжтой бөгөөд алтанд санхүүгийн нарийн төвөгтэй хэрэгслээс илүү итгэдэг явдал юм. Мөн алт нь ихэнх түүхий эд, хувьцаанаас бага хэлбэлзэлтэй байдаг тул данс удирдагчдад хөрөнгө оруулалтын портфолио/багцаа илүү сайн тэнцвэржүүлэх боломжийг олгодог байна. Иймд алтаар хөрөнгө оруулах нь тэдэнд ах зээл тогтворгүй үед эрсдэлээ удирдах илүү их боломжийг өгдөг. Үүнтэй ижил шалтгаанаар мөнгө угаадаг зохион байгуулалттай гэмт бүлгүүд гүйлгээ хийхдээ, ялангуяа гадаад төлбөр тооцоо хийхдээ бэлэн мөнгө эсвэл алт гэх мэт үнэт зүйлсийг илүүд үздэг. 6-р кейс судалгаанд гэмт хэрэгтнүүд өөрсдийгөө суурь гэмт хэргээс холдуулахын тулд алтаар хөрөнгө оруулах, алтыг нөөцлөх хүсэлтэй байгааг харуулах болно.

Кейс судалгаа 6. Гэмт хэргээс олсон орлогоор дахин ашиг олох зорилгоор алтаар хөрөнгө оруулах

Үнэт металл хайлуулах, цэвэршүүлэх, хайх, боловсруулах зэрэг бүхий л төрлийн үйлчилгээг санал болгодог Швейцарийн санхүүгийн зуучлагч нэгэн Ази нэртэй этгээдээс имэйлээр бизнесийн санал хүлээн авав. Зуучлагч нь тухайн хүн эсвэл имэйл хаягийг (арилжааны үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан) мэддэггүй байв.

Энэхүү и-мэйл дээр илгээгч нь их хэмжээний алтыг худалдах талаараа мэдэгджээ. Цахим захидалд Швейцарийн нэгэн компанийн толгойтой захидал хавсаргасан байв. Энэхүү захидал дээр хоёрдогч компани нь тус Швейцарийн компаниас боломжит худалдан авагчдыг хайж, алтны гүйлгээнд зуучлагчаар ажиллахыг хүсч байгааг нотолсон байв. Уг захидалд энэхүү хоёрдогч компани нь мөн адил Швейцарьт байрладаг бөгөөд алт борлуулагч буюу банкнаас шууд холбогдсон хэмээн мэдэгдсэн боловч холбогдох банкны нэрийг дурдаагүй байна. Бизнесийн саналыг "алтны томоохон хэлэлцээр" гэж нэрлэсэн бөгөөд борлуулалтын үнэ нь Лондонгийн алтны ханшнаас 4% доогуур байжээ.

Ийм томоохон алтны гүйлгээг голдуу мэргэжлийн санхүүгийн дилерууд хийдэг бөгөөд алтаа зарах гэж байгаа банк нь уг саналд дурдагдаагүй тул мэдээлэх үүрэгтэй санхүүгийн зуучлагч нь энэхүү саналыг хуурамч гэж сэжиглэсэн байна. Түүнчлэн тэрбээр дурдсан хоёр компанийн аль нь ч санхүүгийн зуучлагчаар ажиллах гэрчилгээгүй гэж үзжээ.

МҮЭ-с Швейцарийн СМА-д сэжигтэй гүйлгээний тайлан хүргүүлсэн бөгөөд СМА-ны мэдээллийн сангаас хайсны үр дүнд холбогдох компаниудын нэг төлөөлөгч хэдэн жилийн өмнө гадаадад залилангийн хэргээр яллагдаж байсан нь тодорхой болжээ. Санхүүгийн зуучлагч энэ залилангаас олсон хууль бус орлогын зарим нь магадгүй алт худалдан авахад ашиглагдсан гэж таамагласан байна. Энэ алтыг дараа нь хаа нэг газар хурааж, одоо алтны үнэ өссөн үед зарах оролдлого хийж байх магадлалтай гэж мөн үзжээ.

Швейцарийн СМА нь холбогдох бүх эд хөрөнгийг хурааж авсан эсэхийг лавлахаар гадаадын түнш СМА-тай холбоо барьсан. Гадаадын СМА нь уг этгээд нь залилангийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа бөгөөд түүнийг холбогдох цагдаагийн байгууллага шалгаж байгаа гэсэн хариу өгжээ. Сэжигтэн нь өөрийн нэр болон нууц нэр ашигласан байсан бөгөөд түүний талаарх бүртгэл байхгүй байв. Иймд алт болон гэмт хэргээс олсон орлогыг цааш нь мөрдөх, СГТ-г хууль сахиулах байгууллагад шилжүүлэх боломжгүй болов.

Эх сурвалж: Швейцарийн СМА

АЛТЫГ БИЕТЭЭР БОЛОН ЦАХИМААР ХИЛЭЭР АМАРХАН ХУУЛЬ БУСААР НЭВТРҮҮЛЖ, ХУДАЛДДАГ.

Энэхүү тайланд дурдсан асуулгын хариултын дагуу алтны зах зээлтэй холбоотой мөнгө угаах болон суурь гэмт хэрэг нь гадаад болон дотоод худалдаатай холбоотой болно.

Биет алтны хувьд алтан гулдмайг хайлуулж, алт гэдгийг нь нуухын тулд янз бүрийн хэлбэрт хувиргахад хялбар байдаг. Тухайлбал, алтыг Америкийн бэлэг дурсгал болгон зүүж Хойд ба Өмнөд Америкийн хооронд алт хулгайгаар тээвэрлэхийг оролдсон тухай хэвлэл мэдээллийн

хэрэгслүүдээр мэдээлж байв. Доорх кейс судалгаанууд нь алтыг конус болон гинж, самар, боолт, бүсний төмөр гэх мэт түгээмэл зүйл болгон хувиргасан жишээг харуулна. Эдгээр хэлбэрийн алтыг гаалийн байцаагчдаас нуух нь илүү хялбар бөгөөд гаалийн мэдүүлэг дээр үнийн дүнгийн нэлээд доогуур тэмдэглэж болно.

Кейс судалгаа 7. Алтыг гаалийн байгууллагаас нуухын тулд нийтлэг бараа болгон өөрчилсөн хэрэг

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын мөрдөн байцаах газар ба Дотоодын орлогын албаны Эрүүгийн мөрдөн байцаах газар (IRS) нь алтыг конус шиг нийтлэг бараа болгон хувиргаж, экспортлодог системийг илрүүлжээ. 2001 оны 12-р сараас 2003 оны 5-р сар хүртэл Нью Йорк дахь Манхэттэний Алмазны дүүрэгт алт боловсруулах бизнес эрхэлдэг Росс Рефинерс компанийн эзэн Жэйми Росс нь нууцаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис борлуулж олсон орлогоо угаах ажиллагаа явуулж буй дүр эсгэж байсан гүйцэтгэх ажилтанд их хэмжээний алт зарж байжээ.

Росс алтыг худалдаж авах мөнгө нь хар тамхины борлуулалтаас олсон гэж мэдсэн боловч алтаа зарсаар байв. Тэрбээр алтыг конус хэлбэрт цутгаж, Колумб руу хууль бусаар хил давуулахад баригдахаас зайлсхийхийн тулд алтны өнгийг өөрчилдөг байв. Росс нь 2003 оны 6-р сарын 4-нд баривчлагдсан бөгөөд мөнгө угаах гэмт хэрэг, IRS-ийн алт зарахад хийгддэг бэлэн мөнгөний гүйлгээний талаарх 8300 маягтыг бөглөөгүй хэргээр баривчлагджээ.

Эх сурвалж: АНУ-ын ДАБГ

Кейс судалгаа 8. Эрэг, самар, боолт, бүсний горхи гэх мэт нийтлэг зүйл болгон хувиргасан алт

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын мөрдөн байцаах газрын (HSI) мөрдөн байцаагчид “Хайлуулах үйл ажиллагаа” нь дор хар тамхины борлуулалтаас олсон орлогыг алт мөнгөний дархан алтан бүтээгдэхүүн болгон хувиргадаг тойргийн тогтолцоог илрүүлжээ.

Уг гэмт хэрэгт хар тамхины орлогоос олсон сая сая долларыг Нью Йорк хотын алт нийлүүлэгчидтэй нийлж угаасан гэмт хэргийн байгууллага холбогджээ. ДАБГ-ын судалгаагаар Колумб улсаас экспортлосон алт нь "алтны пигментүүд" гэсэн тодорхойлолттой АНУ-д орж ирсэн бол импортлогдсоны дараа тус бүтээгдэхүүнийг "алтан гулдмай" хэмээн тодорхойлжээ.

Тухайн алтан гулдмайг Нью Йоркруу зөөвөрлөж, хар тамхины наймаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллаж байсан алт мөнгөний дархчуул гинж, самар, боолт, бүсний горхи, чиргүүл гэх мэт түгээмэл бараа болгон хувиргаж байжээ.

Энэхүү хэргийн мөрдөн байцаалтын үр дүнд 23 алт, мөнгөний дархныг мөнгө угаасан хэрэгт буруутгаж, бусад хүмүүстэй хамт баривчилжээ. Түүнчлэн 140 кг алт, 2.8 сая ам.долларын үнэ бүхий 100 гаруй алмаз эрдэнэ, 118 кг кокейн, 6 буу, хоёр тээврийн хэрэгслийг хураан авсан байна.

Эх сурвалж: АНУ-ын ДАБГ

Дахин боловсруулсан алтны тодорхой хэмжээг тогтооход хэцүү байдаг тул тус алтыг нэг газраас нөгөөд шилжүүлэх, тухайлбал дотооддоо эсвэл олон улс руу, хууль бусаар хилээр гаргахад тохиромжтой байдаг байна.

Гэмт хэрэгтнүүд хууль ёсны болон хууль бус (хууль бусаар хил нэвтрүүлэх) аргаар хилээр алт нэвтрүүлэхдээ тээвэрлэгчдийг хөлслөх магадлалтай. Энэ нь гэмт хэрэгтнүүдэд нэрээ нууцлах, алт тээвэрлэлтээс өөрсдийгөө холдуулах боломжийг олгодог.

Зохион байгуулалттай гэмт бүлгүүд хууль ёсны болон гэмт хэргээс олсон орлогоо хууль ёсны болгох, алтыг өөрийн гэмт хэрэг үйлдэж буй байршилд ойртуулах зорилгоор алтны гарал үүсэл/төрөл, тодорхойлолтыг өөрчилдөг байна. Ихэвчлэн хяналт султай газар энэхүү гэмт хэрэг үйлдэгддэг эсвэл гэмт хэрэгтнүүд алтыг хилээр хууль бусаар нэвтрүүлдэг байна.

Зах зээлийн шинж чанараас шалтгаалан зарим тохиолдолд алтны арилжаа явуулахын тулд алт нь заавал бодитоор байх эсвэл шилжих шаардлагагүй байдаг. Нэхэмжлэх дээр арилжаалагдаж буй барааг "алт" гэж тэмдэглэж дотоодын болон хилээр гарч буй их хэмжээний мөнгөний хөдөлгөөнийг зөвтгөхөд ашигладаг байна.

Энэ бол худалдаанд суурилсан мөнгө угаах (ХСМУ) гэмт хэрэг бөгөөд зах зээл өөрөө үүнийг дэмждэг бөгөөд эрсдэлтэй, өндөр үнэтэй бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардлыг бууруулах зорилгоор үндсэн бараа бүтээгдэхүүнийг хөдөлгөхгүйгээр тээвэрлэх аргыг бий болгосон. ХСМУ гэмт хэрэг нь гэмт хэргээс олсон орлогоо нуун дарагдуулж, хууль ёсны болгох зорилгоор худалдан авалтын гүйлгээг ашиглах үйл явц юм.

Дээр дурдсанчлан алтны салбарт хадгаламж эзэмшигчийн алтан гулдмайд хууль ёсны гэрчилгээ олгодог хадгаламж болон гэрчилгээний төрлийн бүтээгдэхүүн байдаг болно. Эдгээр гэрчилгээ нь гэмт этгээдүүд өөрсдийгөө хөрөнгөөсөө тусгаарлаж, мөнгө угаах өөр нэг механизмыг бий болгодог. Эдгээр гэрчилгээг гуравдагч этгээд худалдаж авах, зарах боломжтой юм.

3. АЛТНЫ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС ХУУЛЬ БУС АШИГ ОЛОХ БОЛОМЖ

Энэ бүлэгт зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн алтны зах зээлийг буруугаар ашиглаж, ашиг олоход хэрэглэдэг аргуудыг тусгасан болно. Бусад үнэт эдлэлийн олборлолттой адил алт нь үйлдвэрлэлээс эхлээд хэрэглэгч ба хөрөнгө оруулагчид хүрэх хүртлээ хэд хэдэн үе шатыг давна. Жил бүр зах зээлд гаргадаг 'шинэ' алтны хоёр үндсэн эх үүсвэр бий. Эхнийх нь олборлосон алт, хоёрдахь нь дахин боловсруулагддаг алт юм. Жил бүрийн алтны үйлдвэрлэлийн гуравны хоёрыг уул уурхайн олборлолт, үлдсэн гуравны нэгийг дахин боловсруулсан алт эзэлдэг байна.

Энэ хэсэгт алтны зах зээл дээр үйлдэгдэж болох аливаа суурь гэмт хэргийн төрлийг тоймлон харуулж, хууль сахиулах болон холбогдох эрх бүхий байгууллагуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлийг илүү сайн ойлгоход нь туслах зорилготой болно. Энэ нь алтны үйлдвэрлэлтэй холбоотой санхүүгийн урсгалын талаарх мэдээлэл хязгаарлагдмал тул энэхүү эрх бүхий байгууллагуудад анхан шатны мэдээлэл олгоход чиглэгдсэн.

Холбогдох эрх бүхий байгууллагууд нь зохион байгуулалттай гэмт бүлгүүд гэмт хэргээс олсон орлогоо зохицуулалттай санхүүгийн салбарт байршуулах, нуун дарагдуулах, алтны салбарын хууль ёсны үйл ажиллагааны орлоготой нэгтгэхийн тулд энэ салбарт орох боломжтойг мэдэж байх ёстой.

Том-дунд хэмжээний уурхай

Томоохон болон дунд хэмжээний уурхай (ТДХУ) нь аж үйлдвэрийн болон механикжсан аргыг ашиглан албан ёсны олборлолт явуулдаг. Энэ салбарт Англо Голд Ашанти, Рио Тинто, Ньюмонт зэрэг томоохон корпорациуд давамгайлж байна. ТДХУ-н үйл ажиллагаанд хувь хүн эсвэл олон нийтээс босгосон их хэмжээний хөрөнгө шаардагддаг. Ийм төрлийн төслүүдэд ороход өндөр саад бэрхшээл тулгардаг байна. 2012 онд PWC-ийн хийсэн судалгаагаар Хятад, Австрали, АНУ, Орос, Перу, Өмнөд Африк, Канад, Мексик, Индонез, Гана, Узбекистан, Бразил, Папуа Шинэ Гвиней, Аргентин, Танзани зэрэг улсууд дэлхийн хамгийн том алт үйлдвэрлэгч орон болохыг тогтоожээ (ач холбогдлын дарааллаар).

- Авилга: ТДХУ-н төслүүдэд байгаль орчин, зохицуулалтын тусгай зөвшөөрөл шаардагдахаас эхлээд уг салбарт нэвтрэхэд олон саад бэрхшээл тулгардаг тул эдгээр үйл ажиллагаа нь томоохон хэмжээний авилгын гэмт хэрэгт өртөмтгий байдаг. Хахууль өгөх замаар шаардлагатай зөвшөөрөл авах нь тухайн аж ахуй нэгжийн ашиг орлогыг нэмэгдүүлж, уул уурхайтай холбоотой зардлыг бууруулдаг ч бусад аж ахуйн нэгж, хувь хүмүүсд хохирол учруулдаг байна.
- Олборлосон хүдрийг хулгайлах: Газрын гүнээс олборлосон алтны хүдрийн агууламжийг зөвхөн багцаалах боломжтой тул зохион байгуулалттай гэмт бүлэг алтны үйлдвэрлэлийн сүлжээнд нэвтэрч, олборлосон хүдрээс хулгайлж, цэвэршүүлэн дараа нь зарж, орлого олох магадлалтай байдаг.

- *Алт олборлохтой холбоотой залилах болон бусад луйврын гэмт хэрэг:* Хүн амын томоохон хэсэг нь алтыг өргөнөөр сонирхдог бөгөөд уул уурхайн гарааны компаниуд эрсдэл өндөртэй байдаг тул алтны зах зээл нь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгүүдэд хууль бусаар мөнгө олох таатай нөхцөлийг бүрдүүлдэг хуурамч схем болон Понзигийн төлөвлөгөө гэх мэт бусад луйварт өртөмтгий байдаг.

Бичил уурхай

Бичил уурхай (БУ) нь энгийн гар багаж хэрэгсэл эсвэл механикжсан тоног төхөөрөмж ашиглан албан бус эсвэл хагас-албан ёсны ашигт малтмалын олборлолт явуулдаг болно. БУ-аар ихэвчлэн хувь хүмүүс, заримдаа улирлын чанартай эсхүл нүүдэлчин аргаар, эсхүл бүлэг хүмүүс алт олборлодог. Энэ хэлбэрийн алт олборлолт нь дэлхийн уул уурхайн нийлүүлэлтийн 12 орчим хувийг эзэлдэг бөгөөд ялангуяа эдийн засгийн хөгжил багатай эсхүл хөгжиж буй орнуудад ихээхэн тооны хүмүүсийг гол орлого болдог байна.

- *Хууль бус олборлолт:* Энэхүү ховор хэлбэрийн уул уурхайг зохицуулахад тулгардаг саад бэрхшээл болон энэ салбарт ороход хялбар байдаг зэргээс шалтгаалан зохион байгуулалттай гэмт бүлэг, террорист бүлгүүд БУ-аас алтны хүдэр олборлох өндөр магадлалтай. ТДХУ-н нэгэн адил авилга нь хууль бус БУ-н үйл ажиллагааг хөнгөвчлөхөд тусалдаг. Кейс судалгаа 9-д хууль бус олборлолтоос ашиг олж буй хэргийн талаар харуулав. Кейс судалгаа 10-т хар тамхины болон террорист зохион байгуулалттай гэмт бүлэг хууль бус алт олборлолтоос олсон орлогоо хэрхэн өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглаж байгааг тайлбарласан болно.
- *Хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлэх:* Хууль бусаар олборлосон алтыг цэвэршүүлэхийн тулд ихэвчлэн өөр улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх шаардлагатай байдаг. Учир нь алт цэвэршүүлэх үйлдвэр нь алтны хүдэр олборлосон улсад байх албагүй. Хууль бусаар олборлосон хүдрийг хилээр зөөвөрлөх үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлгүүд байдаг байна. Кейс судалгаа 11 нь Эквадор дахь БУ болон алт хууль бусаар хил нэвтрүүлсэн хэргийн жишээг үзүүлэв.

Кейс судалгаа 9. Зимбабве- хилээр алтыг хууль бусаар гаргаж, мөнгө угаасан хэрэг

Зимбабвегийн СМА нь Зимбабвегийн санхүүгийн байгууллагаас (Банк А) мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тайланд (СГТ)-д үндэслэн мөрдөн байцаалтыг эхлүүлжээ. Энэхүү СГТ-нд банкны данс эзэмшигч этгээд өөрийн дансанд ZAR 4.1 сая (Өмнөд Африкийн ранд, ойролцоогоор 410 000 ам.доллар) бэлэн мөнгө байршуулахыг завдаж, мөнгөө нэн даруй ам.доллараар буцааж гаргахыг завдсан гэж мэдэгдсэн байв.

Гүйлгээ хийх оролдлого хийхийн өмнө түүний данс хасах дүнтэй байсан тул их хэмжээний мөнгөн хадгаламжийн гарал үүслийн талаар сэжиг төрсөн байна. Банк санхүүжилтийг хууль ёсны гарал үүслээс авсан гэдэгт итгээгүй тул хадгаламжийг хүлээн авахаас татгалзаж, шууд СМА-нд СГТ хүргүүлжээ.

СМА нь тус этгээдээс ярилцлага авахад тэрбээр мөнгөө Квекве (Зимбабвегийн алтны үйлдвэрлэлтэй нэгэн муж) орчимд үйл ажиллагаа эрхэлдэг бичил уурхайчид болон хууль бус дилерүүдээс худалдаж авсан алтаа борлуулж олсон орлого гэж тайлбарласан байна. Квеквэ мужид зөвшөөрөлтэй бичил уурхайчид болон хурдан борлуулалт хийхийг илүүд үздэг хууль бус алт олборлогч нар ноёрхдог аж. Иймд эдгээр хууль бус алт олборлогч нар газар дээр нь бэлэн мөнгө төлдөг дээрх этгээд гэх мэт худалдан авагчдад зардаг. Энэхүү этгээд шиг алт худалдан авагчид бичил уурхайчид болон хууль бус олборлогчдод газар дээр нь бэлэн мөнгөөр төлбөрөө төлөхөөс гадна хууль ёсны тусгай зөвшөөрөлтэй, татварын шимтгэл авдаг худалдан авагчдаас илүү сонирхол татахуйц үнийг санал болгодог нь батлагджээ.

Дээрх этгээд Зимбабветэй хиллэдэг Өмнөд Африкын хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлж, өөр өөр худалдан авагчдад, тэр дундаа зөвшөөрөлтэй алт цэвэршүүлэх үйлдвэрт зарсан гэж мэдэгджээ. Тэрбээр түүний худалдан авагчид эргээд хэсэг алтаа Өмнөд Африкаас Азируу хууль бусаар хил гарган алт мөнгөний дархчуулд зарж борлуулдаг талаар мэдэгдсэн байна. Сэжигтэн энэхүү гүйлгээг хийх нь Өмнөд Африкийн рандыг (Өмнөд Африкт алтаа тушаасан тохиолдолд) ам.доллараар сольж, хар зах дээр илүү их алт худалдан авч, энэхүү үйл ажиллагаагаа цааш нь үргэлжлүүлэх боломжийг олгох зорилготой гэж нэмж хэлэв. Америк доллар нь алт нийлүүлэгчдэд хүлээн зөвшөөрөгдсөн валют юм.

Банк түүний хадгаламжийг хүлээн авахаас татгалзсаны дараа 4.1 сая рандаа хэрхэн зарцуулсан талаар асуухад тэрээр Хараре дахь Өмнөд Африкийн хар захын валют арилжаагаар дамжуулан сольсон талаар олж тогтоожээ.

Энэ хэрэг бол Зимбабвегийн СМА нь хүлээн авч боловсруулсан олон төрлийн ижил төстэй хэргийн нэг юм. Хууль бус алтны наймаачдын цөөн хэсэг нь Өмнөд Африкийн рандыг ам.доллараар солихдоо банканд хандаж байхад ихэнх нь баригдахаас зайлсхийж, гадаад валютын хар зах дээр мөнгөө солиулахыг илүүд үздэг байна.

Эх сурвалж: Зимбабвийн СМА

Кейс судалгаа 10. Терроризмыг санхүүжүүлэх зорилгоор алт олборлох, арилжаалах үйл ажиллагаа – Колумб

Хар тамхи болон террорист зохион байгуулалттай гэмт бүлэг алтны уурхайн нутаг дэвсгэрийг хяналтандаа байлгаж байна. Уурхайг хяналтандаа авахын тулд тус зохион байгуулалттай гэмт бүлэг эзэмшигчдэд нь хүч хэрэглэж, өмчлөлийн эрхээ тэдэнд шилжүүлэхийг шаарддаг байна.

Энэхүү хар тамхи болон террорист зохион байгуулалттай гэмт бүлэг нь уурхайг хууль бусаар ашиглаж, олборлосон хэсэг алтаа хууль ёсны бизнест зардаг бөгөөд төлбөрөө бэлнээр авдаг байна. Үүний дараа зохион байгуулалттай гэмт бүлэг бэлэн мөнгөө террорист ажиллагаагаа үргэлжлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, зэвсэглэл, эм тариа, бусад барааг худалдаж авахад ашигладаг. Үлдсэн алтаа ирээдүйн хэрэгцээндээ хадгалдаг байна.

Эх сурвалж: GAFILAT

Кейс судалгаа 11. Эквадор дахь хууль бус алт олборлолт

2010 онд Эквадорын нутаг дэвсгэрийн 20 орчим хувь нь уул уурхайн нутаг дэвсгэрээр бүртгэгдсэн. Гэсэн хэдий ч Эквадор дахь уул уурхайн салбарын албан бус, заримдаа хууль бус шинж чанар нь Эквадор болон түүний хөрш зэргэлдээ орнууд хичнээн хэмжээний алт олборлож, хууль бусаар гадагш гаргаж байгааг олж тогтооход саад болжээ.

Эквадор жилийн олборлолтоо ойролцоогоор 15-20 тонн алт гэж тооцдог.

2012 онд бичил уурхайгаас зургаан тонн алт олборлосон байна. Энэ нь тус улсад 9.5 сая орчим ам.долларын орлого оруулжээ. Нийт үйлдвэрлэсэн зургаан тонн тутмын хоёр орчим тонн нь дотоод хэрэглээнд зориулагдсан (үнэт эдлэлийн зориулалтаар) бол үлдсэн дөрвөн тонн нь хууль ёсны дагуу экспортлогдсон бөгөөд 2012 онд ойролцоогоор 160 сая ам.долларыг буцаан олгосон байна.

Хууль бус алтны олборлолт нь жилд зургаагаас найман тоннд хүрдэг албан бус тооцоо байдаг. Энэ олборлолтын нэлээд хэсгийг нь хууль бусаар хил давуулдаг. Энэ нь хөрш орнуудад алтаа зарах нь илүү хялбар байдагтай холбоотой. Учир нь Эквадораас ялгаатай нь тэдгээр улсад зөвшөөрөл шаардагддаггүй.

Эх сурвалж: Эквадорын СМА

Дахин боловсруулалт

Дахин боловсруулсан алт жил бүр зах зээлд нийлүүлж буй шинэ алтны гуравны нэг орчим хувийг эзэлдэг. Дахин боловсруулсан алтыг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, жижиглэнгийн үйлдвэрлэлээс гаргаж авсан хаягдал, үнэт эдлэлээс гаргаж авдаг байна. Алтны хэрэглээ өндөр улсад алтыг их хэмжээгээр дахин боловсруулах магадлалтай байдаг бөгөөд дахин боловсруулалт нь алт олборлож байгаа газар нутгаас хамаарахгүй болно. 2012 онд АНУ, Итали, Хятад, Энэтхэг, Арабын Нэгдсэн Эмират, Турк, Их Британи, Мексик, Египт, Индонези улсууд дахин боловсруулсан алт нийлүүлэлтээрээ дэлхийг тэргүүлсэн. Дахин боловсруулсан алтны нийлүүлэлт нь шинээр олборлосон алтнаас илүү алтны эрэлтээс хамаардаг байна.

- Хулгай: Олон улс оронд үнэт эдлэлийн хулгай нь алтны зах зээлд гарч буй үндсэн гэмт хэргийн чухал хэлбэр болно. Алтны бэлэн мөнгөний бизнес эрхлэгчид гэмт хэрэгтнүүдэд хулгайлсан алтаа хууль ёсны өмчлөгч нь гэдгээ нотлох шаардлагагүйгээр бэлэн мөнгөөр солих боломжийг олгодог.

Хайлуулалт/Цэвэршүүлэлт

Олборлосон болон дахин боловсруулсан бүх алтыг цэвэршүүлж, "хөрөнгө оруулалтын чанар" бүхий сорьцод хүргэх шаардлагатай. Алт олборлож байгаа газрын харьяа нутаг дэвсгэрт алт цэвэршүүлэх үйлдвэрүүд байж болох ч, ихэнх тохиолдолд байдаггүй.

- Хилээр хууль бусаар нэвтрүүлэх: БУ-н хэсэгт дурдсанчлан хууль бусаар олборлосон алтыг хайлуулахын тулд ихэвчлэн цэвэршүүлэх үйлдвэрлүү хилээр хууль бусаар нэвтрүүлэх шаардлагатай болдог. Хууль бус хайлуулалтын эсрэг зарим арга хэмжээ авагдаж байгаа боловч хууль ёсны болон хууль бус уурхайгаас алтыг хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг өргөнөөр үйлдэгдэж байгаа нь нотлогджээ.
- *Хуурамч мэдүүлэг/ залилан мэхлэх*: Зохион байгуулалттай гэмт бүлгүүд ашиг олох, гэмт хэргээс олсон хэрэгсэл, орлогоо зөвтгөх зорилгоор алтны сорьц, жин, гарал үүсэл, үнэ цэнийг буруу мэдүүлэх магадлалтай байдаг. Кейс судалгаа 12-оос харахад гаальд худал мэдүүлэг өгөх нь татвараас зайлсхийх гэмт хэрэгт нөлөөлдөг.

Кейс судалгаа 12. Татварын хөнгөлөлт авахаар хуурамч нэхэмжлэл гаргах- Австрали

Гэмт этгээдүүд алтны арилжаа, цэвэршүүлэлтийг хослуулан улс орны үнэт металлын татварын тогтолцоог ашиглаж болно. Энэ тохиолдолд зохион байгуулалттай гэмт бүлгүүд нь гүйлгээний мөн чанарыг нуух, хууль бусаар татварын буцаан олголт авах эсвэл Австралийн бараа, үйлчилгээний татвар (БҮТ)-ыг төлөхөөс зайлсхийх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтарч гүйлгээг ашиглажээ. Энэ залилах гэмт хэргийг "алга болсон худалдаачин" гэж нэрлэдэг байна.

Мөрдөн байцаалтаар алтан гулдмайнуудыг алт цэвэршүүлдэг компаниар дамжуулдаг бөгөөд тус компанийн мэдэгдсэнээр гулдмайг "өөрчлөхөөс" өмнө татвар ноогдуулах хэлбэрт хуваадаг байна. Дараагаар нь гүйлгээний утга, төлөвийг өөрчилж, хуурамч БҮТ-ын оноо бүрдүүлж, үнэт металлын дилерд БҮТ-гүйгээр зарагджээ. БҮТ-ын хэдэн арван сая австрали долларыг хуурамч нэхэмжлэлийн дагуу олгодог байна.

Ерөнхийдөө гэмт хэргийн үйл ажиллагаа дараах байдлаар явагддаг.

- БҮТ ноогдуулагүй бөгөөд баримтгүй алтны худалдан авалтад БҮТ оноо нэхэмжлэх.
- БҮТ-ын тухай хуульд заасны дагуу алт нь хоёрдогч бараа бүтээгдэхүүний тодорхойлолтоос хасагдсан байдаг ч алтнаас хууль бусаар хөнгөлөлт эдлэх.
- Хуулийн шаардлага хангаагүй алтан гулдмайг татваргүй оруулж ирэх.
- Холбогдох бараа, үйлчилгээний татварын буцаан олголтоос олсон орлогоо хөрөнгө, орлогын албан татварын тайланд мэдүүлэхгүй байх.

Нийлүүлэлтийн гинжин хэлхээний төгсгөлийн оролцогчид татваргүй борлуулалт хийж (алтны хэлбэр өөрчлөгдсөн гэж үзвэл), холбогдох нийлүүлэгчдээс худалдан авалт хийхдээ орлогын албан татварын оноо цуглуулдаг юм. Цаашилбал, зохион байгуулалттай гэмт бүлэгт хамрагдсан хүмүүс залилан хийж олсон татварын буцаалтын орлогоо зохих орлогын албан татварын тайланд мэдүүлэхгүй байна.

Эх сурвалж: Австралийн татварын газар

Алтны жижиглэн худалдаа

Алтны жижиглэн худалдаа нь олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой зах зээл болно. Доор дурдсанчлан энэхүү салбарт үйлдэгдэж буй суурь гэмт хэргийн талаар зарим мэдээлэл байдаг боловч арилжааны явц дахь санхүүгийн урсгалын талаар ойлголт бага байдаг байна. 2012 онд алтны жижиглэн худалдааны хамгийн их эрэлт Энэтхэг, Хятад, АНУ, Турк, Тайланд улсад байжээ. (эрэлтийн хэмжээний дагуу).

- *Залилан:* Алт эзэмших нь соёлын гүн гүнзгий ач холбогдолтой тул зохион байгуулалттай гэмт бүлгүүд цэвэршүүлсэн алтны хуурамч борлуулалтаас ашиг олох зорилгоор олон тогтолцоо боловсруулжээ. Эдгээр тогтолцоо нь үнэт эдлэлийн талаар буруу мэдүүлэг өгөх, хуурамч баримт бичиг үйлдэх, онлайнгаар залилан үйлдэх зэрэг илүү төвөгтэй гэмт хэргүүдээс бүрдэнэ. Жишээлбэл, энэхүү тайланд хувь нэмрээ оруулсан улс орон нь хааны гэр бүлээс алт худалдан авах сонирхолтой түнш хайж буй алтны дилертэй холбоотой луйврыг тогтоосон байна. Мөн хохирогчдыг татах зорилгоор хуурамч холбоо барих хаяг, вэбсайтууд зэрэг мэргэжлийн дүр төрх бүрдүүлсэн байна.
- *Алтны урамшууллын тогтолцоог ашиглах/шулах:* Алтанд суурилсан бараа бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалан олон улс орнууд алтны арилжааг эдийн засагт ашиг тустай гэж үздэг. Энэ шалтгааны улмаас хэд хэдэн улс орон алтны арилжааг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт зэрэг урамшууллын хөтөлбөртэй байдаг. Улс хоорондын өөр өөр тогтолцоог зохион байгуулалттай гэмт бүлгүүд өөрт ашигтай байдлаар буруугаар ашиглах эрсдэлтэй байна.

Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын алт нь тусгай сорьцтой алтны тодорхой ангилал юм. Алт нь зээл болон зээлийн оноо олгодог онлайн алтны худалдааны үйлчилгээгээр дамжин санхүүгийн хэрэгсэл болдог. Алтны арилжаа эрхлэгч болон худалдан авагч нь бодит алт солилцохгүйгээр алтаа авах эрхтэй байдаг.

- *Татвараас зайлсхийх гэмт хэрэг:* Алтыг худалдан авах, нуун дарагдуулахад хялбар байдаг тул алтны түүхий эдийг гадаадын улс оронд хууль ёсны дагуу худалдан авч, тэндээ хадгалах нь татвараас зайлсхийх гэмт хэргийн үндэс болдог. Гадаадын улс оронд хадгалагдаж байгаа алтыг тухайн улсад нь зарж, борлуулах боломжийг зах зээл олгодог. Ингэснээр хадгалагдаж буй алтыг бодитоор авахгүйгээр бэлэн мөнгө авах боломжтой болно.

4. СЭЖИГЛЭХ ҮНДЭСЛЭЛ

МУТС ҮЙЛ АЖИЛЛАГАА (ҮНДСЭН СУУРЬ ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА)

ХАРИЦЛАГЧИЙН ЗАН ТӨЛӨВ

- Харилцагч (болон алтан гулдмайн дилерийг) ямар ч тодорхой шалтгаангүйгээр алтан гулдмайн худалдан авалтаа эрс нэмэгдүүлэх.
- Гадаадын иргэд (болон түүний гэр бүлийн гишүүд) богино хугацаанд олон гүйлгээгээр алтан гулдмай худалдаж авах.
- Хамаарал бүхий хүмүүс (гэр бүлийн гишүүд г.м) тодорхой бус зорилгоор гулдмайг шилжүүлэх.
- Харилцагчийн санхүүгийн профайл нь ажил мэргэжилтэй нь зөрчилдөх. Жишээлбэл, үйлчлүүлэгч нь "оюутан" эсвэл "ачааны машины жолооч" гэсэн мэргэжилтэй боловч их хэмжээний хөрөнгийг алтны хадгаламжид шилжүүлэх.
- Харилцагч алтан гулдмай худалдаж авахдаа шуудангийн хайрцагны дугаараа тэмдэглэхгүйгээр шуудангийн үйлчилгээгээр алтан гулдмай худалдан авах.
- Харилцагчийн профайлтай гүйлгээний шинж чанар, гүйлгээ хийх хэв маяг нь нийцэхгүй, сэжигтэй байх.
- Үл мэдэгдэх харилцагч алт цэвэршүүлэгчээс алтыг гулдмай болгох хүсэлт гаргах.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ШИНЖ ЧАНАР

- Алтны салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд СМА-д тайлан ирүүлэхгүй байх (мэдүүлэх үүрэгтэй тохиолдолд).
- Алтны арилжаа эрхлэхээр бүртгүүлсэн хуулийн этгээдийн нэр өөрчлөгдөх.
- Аж ахуй нэгж нь өөр улсад үйл ажиллагаагаа явуулдаг хэдий ч хуулийн этгээдийг татварын хөнгөлөлттэй бүсэд бүртгүүлэх.
- Хувь хүмүүс болон хуулийн этгээдүүд өөрсдийн эрхэлдэг үйл ажиллагааны шинж чанартай холбоогүй ердийн бус, их хэмжээний мөнгө шилжүүлэх.
- Бэлэн мөнгө эсвэл ижил төстэй төлбөрийн хэрэгсэл (жуулчдын чек, кассын чек, мөнгөн гуйвуулга) зэрэг ердийн бус мөнгө ашиглан бага

дүнтэй гүйлгээгээр банканд хадгаламж байршуулж, алт худалдан авахад ашиглах. Дээр дурдсан төлбөрийн хэрэгсэл дараалсан дугаартай эсвэл олон газраас худалдаж авсан байх магадлалтай бөгөөд төлбөр хүлээн авагчийн мэдээлэлгүй байх магадлалтай.

- Өөр хоорондоо хамааралгүй олон тооны хувийн өмчит компаниуд / хувийн хязгаарлагдмал хувьцаат компаниуд ижил бүлэг хүмүүсийн удирдлагад байх. Ийм хуулийн этгээдийг бүртгэхэд хуурамч хаягийг ашигладаг.
- Хил дамнасан халхавч компаниудын корпорацийн бүтцийг ашиглах.
- Нэг хувь хүний нэр дээр бүртгүүлсэн олон тооны хуулийн этгээдүүд.
- Хуулийн этгээдийг өөр газар бүртгүүлсэн тул арилжааны үйл ажиллагааг хянахад төвөгтэй байх.
- Аж ахуй нэгж худалдаж авсан бараагаа хэрхэн тээвэрлэж байгаа нь тодорхойгүй байх.

ХУДАЛДААНД СУУРИЛСАН ШИНЖ ЧАНАР (ХУДАЛДААНД СУУРИЛСАН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ ХАМААРНА)

- Бэлэн мөнгөөр өндөр дүнтэй худалдан авалт хийх нь худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг (ХСМУ)-ийн үйл ажиллагааны нэг шинж тэмдэг юм.
- Алтны сорьц, жин, гарал үүсэл, үнэ цэнийг хуурамчаар гаальд мэдүүлэх.
- Мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй орон эсхүл ФАТФ-ын стандартыг биелүүлдэггүй орноос алт ирэх болон гарах.
- Эдийн засгийн ямар нэгэн тодорхой шалтгаангүйгээр дээр дурдсан өндөр эрсдэлтэй орноор дамжуулж алтыг тээвэрлэх.
- Ачигдаж байгаа бараа бүтээгдэхүүний хэмжээ, төрөл нь экспортлогч, импортлогчийн чадавх, бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ, хүчин чадалтай нийцэхгүй байх эсвэл тээвэрлэх нь эдийн засгийн хувьд ач холбогдолгүй байх. Өөрөөр хэлбэл харилцагчид тухайн бараа бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх тодорхой санхүүгийн шалтгаан байхгүй байх.
- Фронт болон халхавч компаниудыг ашиглан гүйлгээ хийх. Халхавч ба фронт компаниудыг худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэгт өөр өөр аргаар ашиглах магадлалтай. Халхавч компани нь бодитоор үйл ажиллагаа явуулдаггүй ба мөнгө угаах үйл ажиллагаа, хувь хүний

нэр, мөнгө ба мөнгөний ул мөрийг нуух зорилготой байдаг. Хэрэв үйл ажиллагааг нь мөрдөх үед аливаа компанийг тодорхойлоход энэ нь шууд утгаараа хоосон халхавч байх болно.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИЛАЛТ

- Алтан гулдмайнууд нь үйлдвэрлэлийн стандартад нийцэхгүй шинж чанартай байх.
- Алтны үнэ дотоодын алтны зах зээлийн үнээс өндөр байх.

ТӨЛБӨРИЙН/ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ЧАНАР

- Төлбөрийн сүлжээнд хэд хэдэн хоорондоо хамааралтай байгууллагууд байх.
- Гүйлгээг олон дахин дамжуулж хийх, гүйлгээний утгад өөрчлөлт орох.
- Халхавч компани руу мөнгө шилжүүлэх, мөнгө авах
- Гадаадын аж ахуй нэгжүүдэд хүүгүй зээл олгох.
- Хувь хүнд хүүгүй зээл олгох
- Хувь хүн эсвэл хуулийн этгээд алт олборлох тусгай зөвшөөрөлгүй газраас эсвэл алтны уурхай байхгүй газраас гаралтай гэж мэдэгдэн алт зарах.
- Өндөр дүнтэй гадаад гүйлгээ хийж, дараа нь маш хурдан буцааж авах.
- Хуулийн этгээдийн бүртгэгдээгүй улс оронруу гадаад төлбөр тооцоо хийх.
- Алтны арилжааны салбарт оролцогчид банкны данснаас их хэмжээний бэлэн мөнгө авах.
- Бараа худалдан авахдаа мөнгөө хувааж, чек, бага дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийх.
- Банкны чекээр алтан гулдмай худалдаж авах нь хөрөнгийн гарал үүсэл, эцсийн өмчлөгчийг нуух гэсэн оролдлого байх магадлалтай.
- Алтан гулдмай худалдан авахад бэлэн мөнгө ашиглах, ялангуяа богино хугацаанд олон худалдан авалт хийх эсвэл нэг удаагийн их

хэмжээний худалдан авалт хийх, эсвэл дан ганц алтан гулдмайн худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор дансанд олон удаа бэлэн мөнгө байршуулах.

- Алтан гулдмай худалдан авах гарал үүслийг тогтоох боломжгүй байх. Хэлцэл эсхүл халхавч компаниудтай шууд холбоогүй гуравдагч этгээд эсхүл анхны бичиг баримт, гүйлгээний заавар дээр тусгагдаагүй талууд бэлэн мөнгө (эсвэл төлбөрийн бусад хэрэгслүүд, үүнд чек эсвэл зээлийн карт гэх мэт)-ний гүйлгээ хийх. Бараа худалдаж авсан байгууллагын бүртгэл дээр тэмдэглэгдээгүй банкны чек эсвэл мөнгөн гуйвуулгыг ашиглан барааны төлбөрийг хийсэн гүйлгээг нэмж баталгаажуулах шаардлагатай.
- Дотоодын худалдан авагч ба худалдагч хоорондын гүйлгээний орлогыг гадаадад үл мэдэгдэх гуравдагч этгээдэд шилжүүлэх.

СУУРЬ ГЭМТ ХЭРГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АЛТНЫ УУРХАЙН ШИНЖ ЧАНАР

- Зөвшөөрөлгүй хуулийн этгээд алт олборлох, алтны арилжаа эрхлэх.
- Нэг үндэстэн/ястан уурхайн үйл ажиллагааг гуравдагч этгээдийг хөлсөлж явуулах.
- Тодорхой шалтгаангүйгээр тусгай зөвшөөрөлтэй/лицензтэй уурхай үйлдвэрлэлээ бууруулах.
- Тусгай зөвшөөрөлтэй жижиг буюу бичил уурхайн олборлолтын шинж чанарт тохирохгүй машин, тоног төхөөрөмж ашиглах.
- Захиргааны, техникийн, нийгмийн болон байгаль орчны зохицуулалтыг дагаж мөрдөхгүйгээр уул уурхайн үйл ажиллагааг явуулах.
- Хориглосон газар нутагт уул уурхайн үйл ажиллагааг эрхлэх гэх мэт.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны гол нээлт нь алтны шинж чанарууд гэмт хэргээс олсон орлогоо нуун дарагдуулж, хууль ёсны болгох боломжийг бүрдүүлдэг тул зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн сонирхлыг алт татдаг болно. Алт нь бодит үнэ цэнэтэй, дэлхий даяар бусад валют руу хөрвөх чадвартай, хилээр хууль бусаар нэвтрүүлэхэд хялбар бөгөөд алтыг нэрээ нууцлан арилжаалах боломжтой байдаг байна. Алт бусад үнэт чулуу, металаас ялгаатай нь түүх соёлын өргөн ач холбогдолтой бөгөөд гэмт хэргээс олсон орлогыг бэлэн мөнгө болгоход буруугаар ашиглагдах магадлалтай.

Энэхүү тайланд гэмт хэрэгтнүүдийн алтны зах зээлд орлого олдог арга замуудыг илрүүлсэн болно. Мөн тайланд алт олборлох, дахин боловсруулах, цэвэршүүлэх үйл ажиллагаанууд, алтны жижиглэн худалдаа, хөрөнгө оруулалт зэрэгт гарч болзошгүй зөрчлийг тогтоох зорилгоор олон тооны "сэжиглэх үндэслэл"-үүд буюу анхааруулах шинж чанаруудыг тодорхойлсон. Эдгээр гэмт хэргээс олсон орлогыг угаахад ашигладаг арга зам нь алтны салбараар хязгаарлагдахгүй ч гэмт хэрэгтнүүд алтны өвөрмөц үнэ цэнэ болон зохицуулалттай санхүүгийн салбарт байршуулах, нуун дарагдуулах, хууль ёсны зах зээлд нийлүүлэх үйл явцыг хослуулан алтны зах зээлээс ашиг орлого олох боломжтой болохыг анхаарах хэрэгтэй.


Эдгээр нь чухал нээлтүүд боловч аливаа улс орон болон олон улсын хэмжээнд алтны салбарт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой чиг хандлага, хэлбэрийг тодорхойлохын тулд цаашид нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Энэхүү судалгаанд террорист бүлэг алтны зах зээлийг хэрхэн буруугаар ашигласан талаарх нэг кейс судалгааг оруулсан боловч алтны салбараар дамжуулан террорист бүлгүүд хэр зэрэг хөрөнгө босгож, тээвэрлэж байгаа талаар илүү нарийн судлах нь зүйтэй. Санхүүгийн урсгалаас гадна бараа бүтээгдэхүүний урсгалын талаар илүү их мэдээлэл мөн шаардлагатай байна.

Цаашид алтны үйлдвэрлэл, бөөний худалдаа, түгээлт, борлуулалтын талаарх зохицуулалтын анхан шатны мэдээллийг хууль сахиулах байгууллагуудад өгөх үүднээс алтны салбарын хууль ёсны болон хууль бус бүхий л үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын хяналтыг тоймлох шаардлагатай байна. Хувийн хэвшлийнхэнд өгсөн асуулгад хариулсан компаниудын гуравны нэг нь ямар нэгэн засгийн газар, хууль тогтоомжийн дагуу зохицуулагдаагүй болохыг тогтоов. Эндээс тодорхой дүгнэлт хийх боломжгүй ч алтны үйлдвэрлэлийг дотоод болон олон улсын хэмжээнд хэрхэн зохицуулж байгаа талаар цаашид судлах нь зүйтэй. Энэхүү судалгаанаас алтны салбар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэргийг мөрдөн байцаахад туслалцаа үзүүлэх зорилгоор санхүүгийн мэдээлэл, үйлчлүүлэгчийн дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж байгаа эсэх мөн энэ мэдээлэл нь мөрдөн байцаалтад хэрхэн нөлөөлж байгаа талаарх гол асуулт үүсэж байна.

ХАВСРАЛТ А – АСУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2013 оны 12-р сард Ойрх Дорнод ба Хойд Африкийн ФАТФ-ын шинжээчдийн уулзалтын хэлэлцүүлгийн үеэр эрх баригч, мөрдөн байцаагч, СМА-ийн албан тушаалтнуудаас мэдээлэл цуглуулах зорилгоор санал асуулга боловсруулсан байна. Санал асуулгыг ФАТФ болон ФАТФ-ын төрлийн байгууллагуудаар дамжуулан тараав. Санал асуулгад Аргентин, Австрали, Бельги, Белиз, Бутан, Бруней Даруссалам, Британийн Виржин арал, Болив, Ботсвана, Дани, Эквадор, Сальвадор, Грек, Гватемал, Гайана, Итали, Энэтхэг, Индонез, Япон зэрэг асуулгад хариулсан. Ливан, Малайз, Балба, Шинэ Зеланд, Нигер, Нигери, Өмнөд Солонгос, Перу, Сингапур, Словени, Соломоны арал, Испани, Сент Киттс ба Невис, Швед, Швейцар, Тайланд, Того, Тунис, Турк, Украин, АНУ Америк, Зимбабве зэрэг 41 улс оролцжээ

График 1. Санал асуулгад орсон 41 улс



Хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй зөвшилцөж, ярилцсаны дараа тэдэнд мөн адил асуулга хүргүүлэв. Санал асуулгыг ФАТФ болон ФАТФ-ын төрлийн байгууллагуудын Нарийн бичгийн даргуудаар дамжуулан янз бүрийн орны холбоо барих цэгүүдэд тараасан бөгөөд тэд хариуд нь хувийн хэвшлийнхнээс асуулгын хариултыг авсан болно. Үүнд Австрали, Өмнөд Африк, Эквадор, Индонез, Тайланд, Япон, Лаос, Намиб, Перу, Швейцар улс оролцжээ. Санал асуулга нь уул уурхай, алтны цэвэршүүлэлт, алтны төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, алтны арилжааны салбартай холбоотой дөрвөн хэсгээс бүрдсэн бөгөөд салбарууд дараах байдлаар хариулав:

- Уул уурхайн салбар: 6 орны 16 компани
- Цэвэршүүлэх салбар: 7 орны 17 компани
- Алтны санхүүгийн бүтээгдэхүүний салбар: 3 улсын 10 компани
- Алтны арилжааны салбар: 9 улсын 4 компани

Дараагийн хэсэгт алт олборлох, цэвэршүүлэх, арилжаалахтай холбоотойгоор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, эмзэг байдал болон ийм төрлийн эрсдэл, эмзэг байдлыг

бууруулах, тэмцэхэд чиглэсэн хүчин чармайлттай холбоотой, чухал ач холбогдолтой үр дүнг тоймлосон болно.

АСУУЛГЫН ГОЛ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

Энэхүү асуулгыг хязгаарлагдмал түүвэр дээр үндэслэн хийсэн тул үр дүнг нь таамаглал гэж үзнэ. Гэсэн хэдий ч урьдчилсан дүгнэлт нь энэхүү тайланд дурдагдсан кейс судалгаа, Шанхай, Макао дахь АНДМУТБ-ийн жилийн уулзалт, АНДМУТБ /Евразийн бүсийн бүлгийн Монгол Улсад зохион байгуулсан Типологийн семинар болон Доха хотод зохион байгуулагдсан хамтарсан шинжээчдийн уулзалтын үеэр хийсэн илтгэлүүдээр батлагдсан болно.

Санал асуулгын үр дүнгээс харахад алтны дотоод болон олон улсын худалдаанд ноцтой МУТС эрсдэл, эмзэг байдал үүсдэг байна. Улс орнуудын мэдүүлсэн суурь гэмт хэргийн хамгийн олон тохиолдол нь олон улсын болон дотоодын алтны худалдаа, алттай холбоотой мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой байгаа нь үүнийг нотолж байна. Эрх баригчдын асуулгын хариунаас үзэхэд уул уурхайн салбараас гадна олон улсын худалдааны салбар хамгийн өндөр зохицуулалттай байна. Энэхүү зохицуулалт нь мөнгө угаахтай холбоотой эсэх нь тодорхойгүй байна. Учир нь олон улсын худалдаа нь эдийн засгийн үйл ажиллагааны томоохон хэсэг бөгөөд олон улс оронд өргөн хүрээгээр зохицуулагддаг байна.

График 2. Алтны салбар дахь суурь гэмт хэрэг, мөнгө угаах хэргийн тоо



Эх сурвалж: эрх баригчдийн асуулгын хариулт

Эрх баригчид, албаныхнаас авсан асуулгын хариултаар импортын алт нь алт цэвэршүүлэх үйлдвэр, дотоодын хэрэглээний гол эх үүсвэр болж байгааг харуулж байна. Энэ нь энэхүү судалгааны алтыг ихэвчлэн олборлосон улсад цэвэршүүлдэггүй гэдэг дүгнэлтийг дэмжив. Иймд алтны худалдаанд суурилсан мөнгө угаах эрсдэл, эмзэг байдал байгааг ноолж байна. Илэрсэн суурь гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийн тоо бага боловч гэмт хэрэгтэй холбоотой үнийн дүн маш өндөр байна. Иймд хилээр бага хэмжээний алт зөөвөрлөгдсөн ч их хэмжээний мөнгөн дүн шилжих боломжтой юм. Алттай холбоотой мөнгө угаах үйл

ажиллагааны суурь гэмт хэрэг нь хууль бусаар хилээр бараа нэвтрүүлэх, залилан, авилга, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа зэрэг ноцтой гэмт хэргүүдийг хамардаг.

Алтны худалдаанаас үүсэх эрсдэл, эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд шаардагдах олон улсын хэмжээний уялдаа, холбоотой хамтын ажиллагаа байхгүй байгааг статистикийн үр дүн харуулж байна.

Асуулгад ирүүлсэн алтны салбарын хариултаас харахад хувийн хэвшлийнхэн алтны уурхай, алтны цэвэршүүлэх үйлдвэр, арилжаа, санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой олон тооны ажил эхэлж байна. Ихэнх уул уурхайн компаниуд өөрсдийн олборлосон алтаа боловсруулдаггүй бөгөөд алт цэвэршүүлэх үйлдвэрүүд хүдрээс бусад алт, тэр дундаа хаягдал алт боловсруулдаг байна. Асуулгад хариу ирүүлсэн алт цэвэршүүлэх компаниудын ихэнх нь цэвэршүүлсэн алтны төрлөө тэмдэглээгүй, нууцалсан байдаг. Нөгөө талаар, ихэвчлэн алт худалдаалдаг компаниуд алтны цэвэр байдлыг буюу сорьцыг хэмжих чанарын тэмдэглэгээтэй байдаг.

Алтны бүх дөрвөн гол салбарт (уул уурхай, алт цэвэршүүлэх үйлдвэр, алтны жижиглэн худалдаа, санхүүгийн бүтээгдэхүүн) үйл ажиллагаа явуулдаг компаниудын дийлэнх нь засгийн газрын зохицуулалт, хууль тогтоомжид захирагддаг боловч эдгээр хяналт нь МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаатай хэр хамааралтай нь тодорхойгүй болно. Эдгээр дөрвөн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ихэнх компаниуд гүйлгээгээ албан ёсны банкны сувгаар хийдэг бөгөөд уул уурхайн салбараас бусад гурван салбарын компанийн дийлэнх нь харилцагчийг таньж мэдэх (ХТМ) үүргээ биелүүлсээр байна. Алтны санхүүгийн бүтээгдэхүүний салбарыг эс тооцвол бусад гурван салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын дийлэнх нь олон улсад үйл ажиллагаа явуулдаг гэж мэдэгдээгүй байна. Хачирхалтай нь алтны санхүүгийн бүтээгдэхүүний салбараас гадна бусад салбарын ихэнх компаниуд олон улсын / дотоодын холбоодуудад харьяалагддаг байна.

График 3. Салбар бүрийн ХТМ үйл ажиллагаа



Эх сурвалж: асуулгын хариулт

Жич: Санал асуулгад хариулсан санхүүгийн алтны бүтээгдэхүүний салбар дахь бүх компаниуд ХТМ үүргээ биылээлж байгааг дээрх график дээр харуулав. Үүний нэгэн адил алтны арилжаанд оролцдог ихэнх компаниуд ХТМ үйл ажиллагаа хэрэгжүүлдэг гэж мэдүүлсэн байна.

Дээрх асуулгын хариултууд нь алт олборлох, алтны арилжаанаас үүсэх эрсдэл, эмзэг байдлыг арилгах арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байгаа боловч эдгээр хариу нь зохицуулалттай алтны зах зээлийн салбаруудаас ирсэн бөгөөд албан бус буюу зохион байгуулалтгүй салбарын үр дүн эрс өөр байж болохыг анхаарах хэрэгтэй.

ХАВСРАЛТ Б –АЛТ БОЛОН АЛТНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУУРЬ ГЭМТ ХЭРГИЙГ ХАМАРСАН ДЭЛГЭРЭНГҮЙ КЕЙС СУДАЛГААНУУД

Кейс судалгаа 13. Хууль бусаар хил нэвтрүүлэх/хаягдал алтыг үнэгүйдүүлэх тогтолцоо

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын мөрдөн байцаах газар (ДАБГ) АНУ-д хууль бусаар хаягдал алтыг хэт доогуур үнэлж хилээр нэвтрүүлдэг тогтолцоог илрүүлжээ. 2012 оны 1-р сараас 2013 оны 11-р сар хүртэл АНУ-ын импортлогч (эцсийн хүлээн авагч) нь Төв Америкийн орнуудаас АНУ-д хууль бусаар хаягдал алтыг үнэгүйдүүлэн хилээр нэвтрүүлж байсан бөгөөд улмаар экспортлогчдод хэт өндөр үнээр өгч байжээ.

Энэ хугацаанд Төв Америкийн хоёр компани гаальд мэдүүлсэн дүнгээр нийт 6.4 сая ам.долларын алт АНУ-ын импортлогчдод илгээсэн боловч эргээд тухайн хугацаанд АНУ-ын импортлогч 24 сая орчим ам.долларын төлбөр Төв Америкийн компаниудад шилжүүлжээ. АНУ-ын бизнес эрхлэгчдийг баривчилж, гаалийн зөрчлийг ашиглан мөнгө угаах суурь гэмт хэрэг үйлдсэн хэргээр ял оноожээ.

Эх сурвалж: АНУ-ын ДАБГ

Кейс судалгаа 14. Хар тамхи зөөвөрлөсөн гэж сэжиглэгдсэн алтны уурхайтай гэр бүл

Сэжигтэй гүйлгээний тайлан хүргүүлсэн санхүүгийн зуучлагч байгууллага нь 19-р зуунаас хойш үнэт металлын салбарт үйл ажиллагаагаа эрхэлж ирсэн олон улсын хувийн хэвшлийн компани юм. Швейцар, АНУ дахь компаниуд нь үйл ажиллагааг нь гүйцэтгэдэг байна.

Энэхүү мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ) 2007 оны 6-р сард хоёр уул уурхайн компанийн талаар мэдээлэл хүргүүлжээ. МҮЭ нь хоёр уул уурхайн компанитай бизнесийн харилцаа тогтоосон цагаасаа хойш Швейцар, АНУ-ын Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн дагуу үүргээ биелүүлж ирсэн байна.

Энэ хоёр компани уурхайгаас алтаа МЭҮ- д цэвэршүүлэх зорилгоор илгээдэг байсан. Солилцоо хийгдсэний дараа борлуулалтаас олсон мөнгө компаниудын дансанд шилжүүлэгддэг байсан. Гэсэн хэдий ч 2007 оны 3-р сард хоёр уурхайн эзэмшигчдийн гэр бүлийн тухай сэтгүүлд нийтлэгдсэн байв. Энэ гэр бүл нь хар тамхины наймаа эрхэлж, эд хөрөнгөө галт зэвсгийн наймаанаас олж авсан гэж бичигджээ. 1980-аад онд хоёр уул уурхайн компанийн хувьцаа эзэмшигчидтэй ойр байсан гэр бүлийн нэг гишүүн хар тамхины хэргээр яллагдагчаар татагдсаны дараа цагаатгагдсан боловч хэдхэн жилийн дараа бусдын гарт амиа алджээ. Сэжигтэй гүйлгээний тайланг (СГТ) боловсруулах явцад уул уурхайн хоёр компанийн өмчлөгчийн гэр бүл Перу дахь уурхай худалдаж авсантай холбогдуулан Канадын компанитай шүүх хуралд дуудагдсан байжээ.

Цагдаагийн мэдээллийн санд уг 2 уурхайтай холбоотой мэдээлэл огт байхгүй бөгөөд СГТ-нд зөвхөн нийтлэлүүд орсон байсан тул Швейцарийн СМА хэвлэлийн нийтлэл дэх нотлох баримтууд, тэдгээрийн үнэн зөв байдлын талаар мэдээлэх үүрэгтэй этгээдээс нэмэлт мэдээлэл хүссэн байна. Тухайн үед СГТ-д суурь гэмт хэрэг эсхүл мөнгө угаахтай холбоотой баримт олдоогүй тул СГТ-г хууль сахиулах байгууллагад шилжүүлэх боломжгүй байв. Гэсэн хэдий ч Швейцарийн СМА нь гадны СМА-д холбогдох хүмүүсийн талаарх мэдээлэл авах хүсэлт гаргажээ. Үүний хариуд уурхайн компанийн нэг гишүүнд төсвийн хөрөнгийг

буруугаар ашигласан гэмт хэргээр мөрдөн байцаалт явагдаж байгаа тухай тэр даруй мэдэгдэв.

2007 оны 11-р сард, дээр дурдсан МҮЭ-с дахин СГТ ирүүлжээ. МҮЭ нь нэмэлт судалгаа хийж, хэвлэлийн нийтлэлүүд худлаа болохыг тогтоосон байна. МҮЭ-ийн өмгөөлөгчид хоёр компани болон түүний төлөөлөгчидтэй холбоотой албан ёсны хэрэг бүртгэгдээгүй гэж мэдэгдэв.

Хоёр дахь СГТ-г хүлээн авсны дараа Швейцарийн СМА гадаадын СМА-д нь хоёр компани болон түүний төлөөлөгчидтэй холбоотой мэдээлэл авах хүсэлт дахин хүргүүлжээ. Гадаадын СМА-наас тус 2 компани болон эцсийн өмчлөгчийн гэр бүлийн гишүүдэд холбогдох прокуророос албан ёсны эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа гэсэн хариу өгсөн байна. Гэр бүлийнхэн нь хар тамхины наймааны суурь гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа гэж мэдээлсэн байв.

Энэхүү шинэ мэдээлэл дээр үндэслэн СГТ-г Швейцарийн Ерөнхий Прокурорын газарт шилжүүлэв. Эрх бүхий хууль сахиулах байгууллагын тушаалаар холбогдох этгээдүүдийн эд хөрөнгийг нь хураан авжээ.

Эх сурвалж: Швейцарийн СМА

Кейс судалгаа 15. Алтны зах зээлд залилах гэмт хэргээс олсон орлого

Үнэт металл цэвэршүүлэх, арилжаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн зуучлагч байгууллага Швейцарийн СМА-нд 2014 оны 4-р сард сэжигтэй гүйлгээний тайлан илгээжээ.

СГТ хүргүүлсэн мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ) нь дэлхийн хамгийн том үнэт металлын цэвэршүүлэх үйлдвэрүүдийн нэг бөгөөд Швейцарийн хамгийн том гурвын нэгд тооцогддог. санхүүгийн зуучлагч байгууллага юм. Тус МҮЭ СГТ-д дурдсан харилцагч нь залилах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдаалах, мөнгө угаах зэрэг гэмт хэргээр мөрдөн байцаагдаж, баривчлагдсан болохыг 'нээлтэй эх сурвалж'-аас мэдсэн тул СГТ илгээх шийдвэр гаргасан байна. Зохих хяналт хийсний дараа МҮЭ нь хөрөнгө (жишээ нь цэвэршүүлэх ёстой алт) нь гэмт хэргийн орлого байж болзошгүйг үгүйсгэх аргагүй гэж үзжээ.

СГТ нь 2013 онд 1.1 тэрбум гаруй еврогийн эргэлтийн хөрөнгөтэй, алтны жижиглэн худалдаа эрхэлдэг Испани компанийн гүйцэтгэх захирал болон түүний төлөөлөгчидтэй холбоотой байжээ. Тус компани өөрсдийгөө алтны хөрөнгө оруулалт хийдэг мэргэжлийн арилжааны байгууллага хэмээн тодорхойлсон байна. АНУ-ын хувийн компани нь тус компанийн 51 %-ийг эзэмшдэг бол үлдсэн 49% нь нэгэн Европын сан, түүнээс гүйцэтгэх захирал, Испанийн компанийн төлөөлөгч нь 49 хувийг эзэмшдэг аж. Тус компани алтан гулдмай худалдах, мөн сүүлийн үед үнэт эдлэл болон бусад алтан эдлэлүүдийг худалдан авч, алтан гулдмай болгох чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг байв. 2009 онд тухайн компанийн эргэлтийн хөрөнгө 150 сая еврогоос бага байсан бол 2010 онд 500 сая еврогоос ихэсч. 2012 он гэхэд 2010 оныхоос хоёр дахин нэмэгдэж, 1 тэрбум еврод хүрчээ.

МҮЭ нь тус компанитай алт цэвэршүүлэх, нэрийнх нь өмнөөс маркетинг, борлуулалт хийх гэрээ байгуулсан байв. МҮЭ-ийн өгсөн мэдээлэл ба Швейцарийн СМА-ийн мэдээллийн санд үндэслэн холбогдох хөрөнгө (жишээ нь алт) нь гэмт хэргийн орлого байх магадлалтай гэж үзжээ.

Швейцарийн СМА нь нэмэлт мэдээл авах зорилгоор гадаадын хоёр СМА-д хүсэлт хүргүүлсэн боловч хүсэлтэд зөвхөн нэг гадаадын СМА хариу өгсөн бөгөөд хамгийн чухал ач холбогдолтой мэдээлэл өгөх гадаадын СМА нь хариу өгөөгүй байна. Эцэст нь Швейцарийн СМА СГТ-г хууль сахиулах эрх бүхий байгууллагад шилжүүлжээ. Урьдчилсан мөрдөн байцаалт эхлэхээс өмнө Швейцарийн хууль сахиулах байгууллага нь гэмт хэргийн мэдээлэл, газар дээрх мөрдөн байцаалтын мэдээлэлийг баталгаажихыг хүлээж байв. Харин энэ хугацаанд дээр дурдсан компани нь төлбөрийн чадваргүй болсон гэдгээ зарласан байна.

Эх сурвалж: Швейцарийн СМА

Кейс судалгаа 16. Түүхий эдийн эх сурвалжийг баталгаажуулдаггүй тул алтны салбар нь хулгайлагдсан түүхий эдийн дамжих чухал суваг болж буй хэрэг

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын мөрдөн байцаах газар (ДАБМБГ) нэгэн үнэт эдлэлийн арилжаа эрхлэгч худалдан авагчдаа зарсан үнэт эдлэлээ хулгайлуулах зорилгоор хулгайч хөлсөлдөг тогтолцоог илрүүлжээ.

Тухайн бизнес эрхлэгч үнэт эдлэлээ үйлчлүүлэгчдэд зарж, дараа нь хулгайн гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэг хөлсөлж, бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга, үйлчлүүлэгчдийн оршин суугаа хаяг зэрэг хулгайлагдах үнэт эдлэлийн талаар нарийн мэдээллийг өгдөг байв. Зохион байгуулалттай гэмт бүлэг нь тухайн үнэт эдлэл болон бусад зүйлсийг хулгайлдаг байв.

ДАБГ-ын гүйцэтгэх (нууц) ажиллагааны үеэр үнэт эдлэлийн бизнес эрхлэгч хулгайлагдсан үнэт эдлэлийг гүйцэтгэх (нууц) ажилтнаас худалдаж авсан бөгөөд үнэт эдлэлийг хайлуулан хаягдал алтны хэлбэрээр борлуулах шаардлагатай гэж мэдэгджээ

Үнэт эдлэлийн бизнес эрхлэгчийг баривчилж, мөнгө угаасан, хулгайлагдсан бараа худалдан авсан хэргээр ял оноожээ.

Эх сурвалж: АНУ-ын ДАБГ

Кейс судалгаа 17. Алт зарах нэрийн доор хөрөнгөө өөр улсруу шилжүүлэх - Коста Рика

А улсад үйл ажиллагаа эрхэлдэг компани нь алт, үнэт эдлэл, үнэт чулуу/металыг орон нутгийн зах зээлийн үнээс өндөр үнээр худалдаж авах үйлчилгээ үзүүлэх зорилгоор Б улс руу төлөөлөгчдийг байнга илгээдэг байв. Энэ үйл ажиллагааны үр дүнд алт худалдаж авах үндэслэлээр А улсаас Б улс руу их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ хийгддэг байв. Шилжүүлсэн мөнгийг Б улсын санхүүгийн байгууллагуудаас бэлэн мөнгө эсвэл чек хэлбэрээр богино хугацаанд гаргаж авдаг байна. Худалдан авсан барааны тээвэрлэлтийн талаар мэдээлэл огт байдаггүй байжээ.

Холбогдох байгууллага нь Б улсын тансаг зочид буудалд алт худалдаж авах арга хэмжээ зохион байгуулсан хэдий ч уг арга хэмжээнд цөөн тооны үйлчлүүлэгч ирдэг байв. Энэхүү арга хэмжээг зохион байгуулахад зарцуулсан зардлаас илүү гарсан төсвийг А улсруу буцааж шилжүүлж эсвэл уг компанийн үйл ажиллагаа явуулдаггүй бусад оронд үүнтэй ижил төстэй арга хэмжээнүүдэд ашиглагдана гэж мэдүүлэн шилжүүлсэн байна.

Эх сурвалж: Коста Рика СМА

Кейс судалгаа 18. Бангладеш улсын хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлсэн хэрэг

Энэхүү хэргийг үйлдэхдээ гэмт хэрэгтэн агаарын тээврийг ашиглан хилээр барааг хууль бусаар нэвтрүүлсэн байна. Тэрбээр Саудын Арабын агаарын тээврээр Саудын Арабын Эр-Рияд хотоос Бангладешийн Дакка хотод ирсэн байна.

Гэмт хэрэгтэн металл тээвэрлэж байсныг хилээр нэвтрэхэд нь метал илрүүлэгчээр илрүүлжээ. Ачааг нь онгойлгоход бор картон цаасанд ороосон хоёр ундааны сав олдсон байна. Сав бүрт нь тугалган цаасаар ороосон өндөр сорьцтой 6 алтан гулдмай байжээ.

Түүнчлэн дээрх этгээдийн ачаа тээшинд 135 гр тансаг саван дотор нуусан хоёр 100 гр жинтэй алтан гулдмай, өмдний халаасанд нь 240 грамм жин бүхий 77 алтан гинж, 2 алтан ээмэг байв.

Гэмт хэрэгтэн нь 'ногоон' бүсээр хилээр нэвтэрч байхад нь гаалийн байцаагчид ачаа тээшээнд нь ердийн шалгалт хийж, алт байгааг нь олж тогтоожээ. Гаалийн ажилтнуудад энэхүү гэмт хэргийн талаар өмнө нь ямар нэгэн мэдээлэл ирүүлээгүй байна.

Бангладеш улс нь өвөрмөц алтны зах зээлтэй бөгөөд сүүлийн үед тус улсад албан ёсоор алт импортлогдоогүй ч алтны зах зээлийн үйл ажиллагаа үргэлжилсээр байна. Учир нь хууль ёсны импортын суваг тус улсад байдаггүй тул алт тээвэрлэхийн тулд хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлдэг болжээ. Тус улсад хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлэх нь цаазын ялтай ч уг гэмт хэрэг үйлдэгдсээр байна. Ихэвчлэн энэ гэмт хэргийг хавала аргыг ашиглаж үйлддэг байна.

Бангладешийн хууль сахиулах байгууллага алтны тээвэрлэлтийн талаар судалгаа хийхэд Дубай, Маскот, Эр-Риад хотууд нь алтны бөөний худалдааны үндсэн зах зээл гэдгийг тодруулжээ. Алтыг тэдгээр зах зээлээс худалдаж аваад, Бангладешруу хууль бусаар, эсвэл бусад улсруу Бангладеш улсаар дамжуулж гаргадаг байна. Зарим тохиолдолд ийм алтыг бартер ашиглан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис авдаг болохыг тогтоосон. Алтыг бэлэн мөнгийг хилээр хууль бусаар нэвтрүүлэх эсвэл Хунди аргаар худалдаж авдаг бөгөөд уг гэмт хэрэгт хариуцлага хүлээх хүмүүсийн талаар мэдээлэл хомс байдаг.

Зарим тохиолдолд хууль ёсны байгууллагуудад төлбөр төлөх зорилгоор алтыг хилээр хууль бусаар нэвтрүүлдэг бол бусад тохиолдолд хүмүүс алтны зах зээлийн ханшийн зөрүүнээс ашиг олохын тулд тус гэмт хэргийг үйлддэг байна.

Эх сурвалж: Бангладешийн Хууль сахиулах байгууллага (Цагдаа)

Кейс судалгаа 19. Хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлэх, мөнгө угаах хэрэг – Зимбабве

Тунисын СМА нь иргэн Х тэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) хүлээн авчээ. Уг иргэний дансанд богино хугацаанд их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ хийгдэж, цугларсан мөнгөө тэрбээр ам.доллороор гаргахыг хүссэн байна. СМА-ны дүн шинжилгээний хүрээнд цуглуулсан мэдээлэлд иргэн Х нь хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлдэг сүлжээтэй холбоотой болохыг тогтоов.

А улсад Төв банк нь алтны зах зээлийн хяналт, зохицуулалтыг хариуцдаг байна. Мөрдөн байцаалтаар Х этгээд алтыг төрөл бүрийн хууль бус аргаар, жишээлбэл газрын хилээр хууль бусаар нэвтрүүлэх болон дээрэм тонуулаар оруулж ирсэн болохыг тогтоожээ.

Иргэн Х нь алтыг цэвэршүүлж, гулдмай хэлбэрт оруулан агаарын тээвэрлэгч А-д өгдөг байна. Агаарын тээвэрлэгч А нь гааль, цагдаагийн хяналтыг өнгөрч, онгоцны буудлын бүх бүсэд саадгүй нэвтрэх боломжтой байжээ. Этгээд А түүнд өгсөн гулдмайнуудыг хаалганы ойролцоох ариун цэврийн өрөөнд үлдээж, алт тээвэрлэгч Ү-тэй утсаар холбогдон, хаана байрлуулснаа хэлдэг байв.

Гэмт хэрэгтэн Ү нь ачаагаа аваад Т улс руу нисэж, иргэн Z-д хүлээлгэн өгсөн байна. Мөн тэрбээр алтны төлбөрөө авч, А улсад буцаж очоод иргэн Х тэй ашигаа хуваажээ.

Сарын дараа Тунийн СМА нь иргэн Х-ийн талаар нэмэлт мэдээлэл авав. Тухайн өдөр иргэн Х өөрийн эзэмшдэг компанийнхаа дансанд бэлэн мөнгө байршуулж, гүйлгээний мөн чанар, өөрийн нэрээ нууцлах гэж оролдсон боловч банк анхны сэжигтэй гүйлгээнийх нь дараа түүний нэрийг анхааралдаа авсан байсан тул уг сэжигтэй гүйлгээг дахин илрүүлж чадсан юм. Иргэн Х нь компанийнхаа дансанд 2.39 сая өмнөд африкийн валют (ойролцоогоор 239 000 ам.доллар) байршуулж, удалгүй ам.доллороор гуравдагч этгээд болон харилцаа холбооны компани руу шилжүүлжээ.

Зимбабвегийн СМА-ны мөрдөн байцаалтаар Өмнөд Африкийн валютыг өмнөх шигээ шууд бэлэн ам.доллороор авах гэж оролдолгүй, өөрийн нэр дээрх хуулийн этгээдийн дансаар харилцаа холбооны компанийн данс руу гар утасны нэгж худалдаж авах өндөр дүнтэй гүйлгээ олон удаа хийсэн байна.

Мөрдөн байцаалтын явцад иргэн Х нь Квекве хот (Зимбабве) болон ойролцоо хотуудад байрладаг гар утасны нэгж борлуулагчдын нэрийн өмнөөс их хэмжээгээр худалдан авалт хийсэн бөгөөд компанийнхаа дансанд байсан Өмнөд Африкийн валютаар худалдан авалт хийжээ. Харин тухайн нэгж борлуулагчид иргэн Х-д бэлэн ам.доллороор төлбөрөө төлдөг байв. Ингэснээр гэмт этгээд Х нь валютаа ам долларт хөрвүүлж, дахин алт худалдан авах, хилээр хууль бусаар гаргах үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг байв.

Эх сурвалж: Зимбабвегийн СМА

Кейс судалгаа 20. Гуравдагч этгээдийн данс ашиглан хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлж, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх хэрэг

Банк Б-с СМА-нд иргэн З-тэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайланг ирүүлэв. Иргэн З нь Өмнөд Африкийн валютаар олон удаагийн гүйлгээгээр их хэмжээний бэлэн мөнгө өөрийн эзэмшдэг компанийн хадгаламжид байршуулжээ. Дараагаар нь бэлэн ам.доллараар буцааж гаргасан байна. Тэрбээр нийтдээ 6.6 сая ам. доллар бэлэн мөнгөөр гаргажээ.

Зимбабвегийн СМА-ны дүн шинжилгээгээр иргэн З нь алтны дилерийн нэрийн өмнөөс шимтгэлтэй гүйлгээ хийж байсан нь тогтоогджээ. Иргэн З-ийн найз нь хууль бус алт арилжаалагчдаас алт худалдан авч, улмаар хилээр алтыг хууль бусаар гаргасан хэрэгт холбоотой байв. Энэ хэргийн 6.6 сая ам.долларын санхүүжилт дээр үндэслэн тооцож үзэхэд нэг тонн гаруй алтыг хууль бусаар худалдан авч, хилээр гаргасан гэж үзэж байгаа юм.

Эх сурвалж: Зимбабве СМА

Кейс судалгаа 21. Пакистаны алтны худалдаа - Алтны импортыг түр хориглох хуулийн санаачилга

Пакистаны засгийн газар экспортыг төрөлжүүлэх санаачилга гаргаж, нэмүү өртөг шингэсэн алтны бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилгоор алтны тухай хууль санаачлав. Энэ хүрээнд үнэт эдлэл арилжаалагчдын экспортыг дэмжин нэмүү өртөг шингээсэн алтны үнэт эдлэл хийж, экспортолсон нөхцөлд алтыг татваргүйгээр импортлох боломж бүрдүүлж өгчээ.

Энэхүү тогтолцоонуудыг "Итгэмжлэл" ба "Өөрөө тээвэрлэх" тогтолцоо гэж нэрлэжээ. Итгэмжлэл тогтолцооны дагуу экспортолж буй алтны хэмжээ нь экспортлох эд зүйл үйлдвэрлэхэд гарсан хэвийн хорогдлыг нэмээд импортын алтны хэмжээтэй тэнцэх ёстой. Энэхүү тогтолцоо нь гадаадын худалдан авагч, экспортлогч эсвэл эрх бүхий төлөөлөгчид нь алтыг агаарын/далайн ачаагаар илгээх эсвэл өөрийн биеэр Пакистанд авчрах боломжийг олгодог. Харин Өөрөө тээвэрлэх тогтолцоо нь экспортлогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч алт, үнэт эдлэл, эрдэнийн чулууг Пакистанаас экспортлох үйл ажиллагааг зохицуулдаг байна. Шаардлагатай бүх ачааг хянахаас авахуулаад хоёр тогтолцоог хэрэгжүүлэхэд хатуу журам хэрэгжүүлдэг байв.

Эдгээр тогтолцоо хэрэгжих явцад алт импортлогчид Пакистанд алтыг хууль бусаар хил давуулж, дээр дурдсан тогтолцооны журмыг зөрчиж байгаа гэх мэдээлэл гарсан тул Пакистаны мөнгөн тэмдэгт ханшийн дарамтад орсоор байв.

Иймд Пакистаны засгийн газар үндэсний эдийн засагт цаашид хохирол учруулахгүйн тулд яаралтай арга хэмжээ авчээ. Тухайн улсад алтыг гаалийн татваргүй импортлоход богино хугацааны буюу 30 хоногийн хугацаатай хориг тавих шийдвэр гаргасан байна. Энэ нь хуулийн цоорхойтой, дутагдалтай тогтолцоонуудыг өөрчлөн шинэчлэх боломжийг олгосноор алтны үнэт эдлэлийн экспортыг нэмэгдүүлэх үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд дөхөм болгожээ. Эдгээр шинэчлэлд нэг талд импортлох алтны хэмжээг хязгаарлах, алтыг алтны үнэт эдлэл хэлбэрээр экспортлох хугацааг богиносгох, Пакистан улсын эрх баригчдын зүгээс холбогдох бүх хяналтыг чангатгах зэрэг багтсан болно. Түүнчлэн

Пакистаны Засгийн газар тээвэрлэлтийн үед аливаа хэрэг гарч байгаа эсэхийг шалгаж эхэлсэн байна.

Эх сурвалж: Пакистан Улс

Кейс судалгаа 22. Алт, үнэт эдлэлийг Чөлөөт бүсээс хууль бусаар хил гаргах

Чөлөөт бүс (ЧБ) нь гадаад валютын орлого олох зорилгоор худалдаа, экспортыг дэмжихэд байгуулагдсан тусгай бүс юм. Чөлөөт бүс нь гаалийн татвараас чөлөөлөгдсөн байдаг. Гэвч ЧБ-ийн хялбаршуулсан хяналт, шалгалтаас үүдэж эдгээр бүсүүд мөнгө угаах, татвараас зайлсхийх гэмт хэрэгт өртөмтгий байдаг.

Нөхцөл байдал: Энэхүү судалгаанд дурдагдах компаниудын захирлууд ЧБ -д үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 25 жилийн турш Энэтхэгт алтны худалдаа эрхэлжээ. Тэд өмнө нь хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлсэн хэргээр шалгагдаж байсан бөгөөд гааль/гадаад валютын татвар болон орлогын албан татвараас зайлсхийх гэмт хэрэг үйлдэж байв. Захирлуудынхан нэг нь мөн Дубайд алтны үйлдвэрлэл, арилжаа эрхэлдэг байв.

Үйл ажиллагаа: ЧБ-эд байрлах А, Б компаниуд алтан эдлэл үйлдвэрлэх, худалдаалах эрхтэй байсан. Иймд эдгээр компаниуд алтыг гулдмай эсвэл хагас боловсруулсан үнэт эдлэл хэлбэрээр гадны улс орнуудаас импортлох эрхтэй байв. ЧБ-ийн онцлог шинж чанар нь бараа импортлох, экспортлох үед эрх бүхий байгууллагаас төдийлөн хатуу хяналт, шалгалт хийгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн эдгээр компаниуд үйл ажиллагаа нь тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд экспортын бараандаа өөрсдөө гэрчилгээ олгодог байжээ.

В, Г компаниудын төлөөлөгчид (ихэнх тохиолдолд гэр бүлийн хүмүүс нь удирддаг) гадаад руу явж, Энэтхэгийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй үнэт эдлэлийг сонгодог байжээ. Тэд үнэт эдлэлээ худалдаж авахдаа тухайн улсдаа шууд төлбөр тооцоогоо хийдэг байв. Дараа нь ЧБ-д хаягдал алт эсвэл дахин боловсруулах үнэт эдлэл хэмээн гаальд мэдүүлж хилээр нэвтрүүлдэг байв.

Гаалийн бүрдүүлэлт хийсний дараа барааг онгоцны буудлаас ЧБ (20 км зайтай) руу тээвэрлэж, замд нь холбогдох компанийн ажилчид эсвэл захирлуудын аль нэг нь импортын битүүмжилсэн багцыг гууль, хаягдал металл эсвэл бусад дууриамал үнэт эдлэл агуулсан битүүмжилсэн багцаар сольдог байжээ. Импортлож байсан жинхэнэ алтан үнэт эдлэлийг дараа нь хууль ёсны алтны зах зээл дээр худалдаалдаг байв.

Гууль, хаягдал металл эсвэл бусад дууриамал үнэт эдлэлтэй битүүмжилсэн багцанд алт, үнэт эдлэл гэсэн гэрчилгээ олгож, дараа нь өөрсдийн харьяа компаниудад экспортолдог байжээ. Энэ тогтолцоо нь үнэт эдлэлийг ЧБ-ээс экспортлоход гэнэтийн хяналт шалгалт хийдэггүйгээс үүдсэн байна.

Дээр дурдсан компаниудын захирлууд 1 грамм алт тутамд хүргэлтийн төлбөр болгон үйлчлүүлэгчдээсээ 25 Энэтхэг рупийгийн төлбөр авч, Энэтхэгт худалдан авагч олж өгсөн хүмүүст 1 грамм алт тутамд 5 рупийн төлбөр төлдөг байжээ.

Хэмжээ: Энэтхэгийн Орлогын тагнуулын ерөнхий газрын мөрдөн байцаалтын явцад ойролцоогоор 3 сая ам.долларын үнэ бүхий 79 кг алтан үнэт эдлэлийг хураан авчээ. 7 сая долларын үнэ бүхий 190 кг алтан эдлэл агуулсан гэж мэдүүлсэн экспортын барааг шалгахад төмрийн хаягдал агуулсан байв. Түүнчлэн, мөрдөн байцаалтын явцад холбогдох компаниас 100,000 ам.доллар бэлэн мөнгө, 1.2 сая ам.доллар үнэ бүхий 30 кг алтан эдлэлийг тус тус хураан авчээ. Эргэлзээтэй импортын нийт хэмжээ 100-120 сая ам.доллар байсан бол гааль болон бусад татвараас зайлсхийсэн нийт дүн нь 10 сая долларт хүрсэн гэсэн дүгнэлт гарчээ.

Эх сурвалж: Энэтхэг улсын Хууль сахиулах газар

Кейс судалгаа 23. Алтны бизнестэй холбоотой олон улсын мөнгөн гуйвуулага

Санхүүгийн тагнуулын төв (СТТ, Өмнөд Африкийн СМА)-д иргэн А нь АНУ-аас 2012 оны 8-р сард 129,995.17 ам.долларын гүйлгээ хүлээж авсан гэсэн СГТ ирүүлжээ.

СТТ-ийн дүн шинжилгээгээр иргэн А нь нэг банканд дөрвөн өөр данстай бөгөөд гүйлгээ хийгдэхээс өмнө бүх данс нь идэвхгүй байсан нь тогтоогджээ. Тэбээр алтны компани байгуулж, дөрвөн жилийн турш үйл ажиллагаагаа явуулж байгаа гэж мэдэгдсэн боловч бизнес эрхэлдэг гэсэн нотлох баримт олдоогүй байна.

Иргэн А ийн мэдүүлснээр дээр дурдсан гүйлгээ нь АНУ-ын Европ дахь үнэт эдлэлийн дэлгүүртэй түншүүдээс нь ирсэн байв. Түүнчлэн тэрбээр хар захаас алтаа худалдаж аваад АНУ-руу илгээсэн гэж мэдэгдсэн. Цахим хайлтаар хуурамч алтны наймаачинд залилуулсан хэд хэдэн гадаадын хөрөнгө оруулагчдын дунд иргэн А байгааг илрүүлжээ.

Эх сурвалж: Өмнөд Африкийн СМА

Кейс судалгаа 24. Алтны үнэт эдлэл экспортлохтой холбоотой залилангийн хэрэг

Үнэт эдлэл үйлдвэрлэдэг компанийн стратеги/эдийн засгийн зөвлөх нэгэн арилжааны компанийн ахлах ажилтан А-г залилангийн гэмт хэрэг үйлдэх хуйвалдаанд оролцохыг ятгаж, үнэт эдлэлийг арилжааны компани А-ийн нэр дээр экспортлуулахаар болов. Гэхдээ бусад үйл ажиллагааг хуйвалдагч тал хариуцах болно гэж зөвлөх мэдэгджээ.

Гэрээнд заасны дагуу арилжааны компани А нь төлбөрийн 80%-ийг үнэт эдлэл экспортолсны дараа үнэт эдлэл үйлдвэрлэдэг компаниудад шилжүүлж, харин экспортолсон бараа зарагдсаны дараа ойролцоогоор 170 хоногийн дараа орлогоо эргүүлж авдаг байв.

Компани А нь эхний жилдээ экспортын бүх орлогоо гадаад худалдан авагчдаас авч байжээ. Хоёрдахь жилд экспортын эргэлт хоёр дахин нэмэгдсэн ч орлогын ердөө 15% буцаж ордог байв. Алтны үнэт эдлэлийг экспортлох үед хуйвалдагчид барааг экспортолсон нотолгоог А компанид харуулдаг байжээ. Компани А нь 170 өдрийн дараа орлогоо хүлээж авдаг байсан тул банкнаас зээл авав. Хэсэг хугацааны дараа компани А нь гадаадад байгаа импортлогчдоос экспортын орлогоо авч чадаахаа байсан болно. Банк, худалдааны компани А нь экспортын орлогоо буцаан авч чадаагүйн улмаас алдагдал хүлээв. Үнэт эдлэл үйлдвэрлэгчид болон залилангийн хуйвалдагчид компани А болон банкныг залилжээ.

Хууль сахиулах газрын явуулсан мөрдөн байцаалтаар үнэт эдлэлийг үнэт эдлэл үйлдвэрлэгчдийн гадаад дахь хамаарал бүхий компаниудад экспортолжээ. Тэд экспортолсон үнэт эдлэлээс олсон ашгаа өөрсдөө авсан байж. Үнэт эдлэл үйлдвэрлэгч А худалдааны компаниас авсан урьдчилгаа төлбөрийг үл хөдлөх хөрөнгө гэх мэт бусад бизнесүүдээр дамжуулан мөнгө угаах гэмт хэрэг үйлджээ. Хууль сахиулах газар хэрэгт холбоотой хөрөнгийг мөрдөн байцаалтаар олсон байна. Одоогоор мөрдөн байцаалтын үйл ажиллагаа гадаадад үргэлжилж байгаа.

Эх сурвалж: Энэтхэг улсын Хууль сахиулах газар

Кейс судалгаа 25. Гана улсын алтны луйвар

2011 оны 8-р сард нэгэн хуульч интернет ашиглан Ойрхи дорнодын бизнесменийг гэмт бүлгээс алт худалдан авах санал тавьж, Гана Улс руу авч ирэх урьхиндаа оруулав. Энэхүү өмгөөлөгч нь худалдан авагч, худалдагчийг хоёуланг нь төлөөлдөг байжээ.

Худалдан авагч бизнесмен Гана дахь банкинд (банк А) 3.5 сая ам. доллар байршуулсны дараа гэмт этгээдүүд бэлэн мөнгөөр гарган авчээ. Гүйлгээ хийгдсэний дараа тохиролцсон алтны зөвхөн 1% -ийг түүнд өгчээ. Бизнесмен үлдсэн алтаа шаардахад зохион байгуулалттай гэмт бүлэг түүнийг айлган сүрдүүлж эхэлсэн бөгөөд нэгэн цагдаад хахууль өгч түүнийг Гана улсаас хөөн гаргажээ.

СМА нь янз бүрийн банкуудаас сэжигтнүүдийн талаарх мэдээлэл болон бусад улсаас хуульчтай холбоотой мэдээлэл лавлаж, мөрдөн байцаалтыг эхлүүлжээ. Дараа нь энэ мэдээллийг хууль сахиулах байгууллагад шилжүүлэв. Хуульчийг баривчилж, хэрэгт холбогдсон цагдаагийн даргыг 2 долоо хоногийн турш цагдан хорьсон байна.

Прокурорын газраас мөрдөн байцаалт явуулж, нотлох баримтууд нь алдаатай, хангалтгүй гэж үзсэн тул хэрэг өдийг хүртэл шийдэгдээгүй юм.

Эх сурвалж: Гана СМА

ЭХ СУРВАЛЖ

FATF (2013a), *Money Laundering and Terrorist Financing through Trade in Diamonds*, FATF, Paris, France,

www.fatf-gafi.org/topics/methodsandtrends/documents/ml-tf-through-trade-in-diamonds.html

FATF (2013b), *The role of hawala and other similar service providers in money laundering and terrorist financing*, FATF, Paris, France,

www.fatf-gafi.org/topics/methodsandtrends/documents/role-hawalas-in-ml-tf.html

FATF (2006), *Trade Based Money Laundering*, FATF, Paris, France www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Trade%20Based%20Money%20Laundering.pdf

PricewaterhouseCoopers (2013), *The Direct Economic Impact of Gold* (referred to as the ‘PWC Report’), PricewaterhouseCoopers LLP for World Gold Council, www.gold.org/research/direct-economic-impact-gold, accessed June 2015.

BJA and N.A.G. (2013), *The Gold Report* (referred to as the ‘Gold Paper), British Jewellers’ Association and the National Association of Goldsmith’s of Federation House, Birmingham and London resp., United Kingdom, www.cibjo.org/download/gold_paper_feb2013_formatted.pdf, accessed June 2015.

ТӨСЛИЙН БАГ

Балеш Кумар

Тусгай захирал

Хууль сахиулах газрын захирал, Энэтхэг

И-мэйл: balesh.kumar@nic.in

Николас Мактагарт

Ахлах мөрдөгч

Гэмт хэргээс олсон хөрөнгийг хурааж авах ажлын хэсэг

Ноцтой зохион байгуулалттай гэмт хэргийн алба

Австралийн Холбооны Цагдаагийн газар

E-mail: nicholas.mctaggart@afp.gov.au

